

# Хамгийн чухал нь сүрьеэг өртсөн Хүмүүс

ОЛОН НИЙТИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ УДИРДАМЖ





# Хамгийн чухал нь сүрьеэг өртсөн хүмүүс

/ОЛОН НИЙТИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ УДИРДАМЖ/

**ACT!**  
ACTIVISTS' COALITION ON TB  
ASIA-PACIFIC



# Хамгийн чухал нь сүрьеэг өртсөн хүмүүс

ЮЛОН НИЙТИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ УДИРДАМЖ



*Хамгийн чухал нь сүрьеэд өрсөн хүмүүс  
/Олон нийтийг татан оролцуулах удирдамж/*

Зохиогчийн эрх © 2023

АКТ! АП (Ази Номхон Далайн Сүрьеэгийн Эсрэг  
Тэмцэгчдийн Эвсэл)

болон АПКАСО (Ази Номхон Далайн Бүсийн ДОХ-ын Эсрэг  
Үйлчилгээний Байгууллагуудын Зөвлөл)

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Энэхүү номын аль ч хэсгийг зохиогчийн эрх эзэмшигч  
болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр ямар ч хэлбэрээр,  
ямар ч аргаар хуулбарлаж болохгүй.

*Зохиогч:*

**АПКАСО**

66/5, 33 цамхаг, Сой Сүхумвит 33

Сүхумвит зам, Клонгтон Нуа, Ваттана

Бангкок 10110 Тайланд

Утас: +66 (0)2 044 8800

Имэйл: [secretariat@apcaso.org](mailto:secretariat@apcaso.org)

Вэбсайт: [www.apcaso.org](http://www.apcaso.org)

**Хэвлэлийн баг:**

Мангала Намасиваям: *Төслийн зохицуулагч*

Мариа Лени И. Феликс: *Зохиолч*

Мария Виржиниа М.Торрес: *Редактор*

Олдрин Барон Катимбанг: *Зураач*

Виктор Деннис Т. Ниерва: *Номын дизайнер*

**Монгол хэлний орчуулга:**

*Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо*

*М.Ганзориг: Хянан тохиолдуулсан*

*Ц.Базаррагчаа: Хянан тохиолдуулсан*

*Тайландад хэвлэгдсэн*

# Агуулга

Өмнөх үг	ix
Талархал	xi
Товчлол, нэр томьёо	xii
Тайлбар толь	xiii
Энэхүү номыг хэрхэн ашиглах тухайд	xv
Оршил	xviii

## 1-Р ХЭСЭГ

<i>Сүрьеэтэй тэмцэхэд олон нийтийг татах үзэл санаа, ойлголт</i>	1
--	---

1.1	Урьдчилсан нөхцөл, утга санаа	2
1.2	Зорилго	8
1.3	Үндсэн зарчмууд	13
1.4	Үндсэн үнэ цэнэ	15

## 2-Р ХЭСЭГ

<i>Олон нийтийн оролцооны тоглогчдын үүрэг, хариуцлага, чанар</i>	18
---	----

2.1	Олон нийтийн оролцооны тоглогчдын үүрэг, хариуцлага	19
2.1.1	<i>Сүрьеэд өртсөн олон нийт, түүний гишүүд</i>	20
2.1.2	<i>Олон нийтийн удирдагчид</i>	21
2.1.3	<i>Олон нийтийн оролцооны түншүүд</i>	24
2.2	Олон нийтийн оролцооны тоглогчдын чанар чансаа	28

### 3-Р ХЭСЭГ

#### Сүрьеэд өртөгсөдийн тогтвортой сүлжээг бий болгоход оролцох олон нийтийн оролцоо: үйл явц, арга хэлжээ 31

3.1	Бэлтгэл үе шат	33
3.1.1	Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах	33
3.1.2	Олон нийтийн оролцооны төлөвлөгөө боловсруулах	37
3.1.3	Нөөц болоцоог дайчлах	40
3.1.4	Харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах	41
3.2	Олон нийтийг дайчлах үе шат	47
3.2.1	Олон нийтийн бэлэн байдал	48
3.2.2	Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд болон удирдагчдын чадавхийг дээшлүүлж бататгах	51
3.2.3	Сүлжээ бий болгох	56
3.2.4	Олон нийтийг дайчлах үйл ажиллагаа	62
3.2.5	Олон нийтийн дайчилгааны оролцоонд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	66
3.3	Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх (CSS) үе шат	71
3.3.1	Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх ажиллагааны тодорхойлолт ба зорилго	71
3.3.2	Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх ажиллагааны хүрээ ба бүрэлдэхүүн хэсгүүд	72
3.3.3	Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд сүрьеэд өртсөн олон нийтийн оролцоо	74

### 4-Р ХЭСЭГ

#### Олон нийтийн оролцооны оролцоонд зориулсан хэрэгслүүдийн эмхтгэл 81

4.1	Олон нийтийн оролцоонд үр дүнтэй тоглогчдын үзэл баримтлал, үүрэг, хариуцлага, шинж чанарыг ойлгох хэрэгслүүд	82
4.1.1	Олон нийтийн оролцооны тухай үзэл баримтлалын танилцуулга	83



4.1.2	<i>Олон нийтийн оролцоонд үр дүнтэй тоглогчдын хүлээх үүрэг, хариуцлага, чанарын танилцуулга</i>	86
4.2.	Олон нийтийн оролцооны хэрэгсэлд бэлтгэ	92
4.2.1	<i>Бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах</i>	92
4.2.2	<i>Олон нийтийн оролцооны төлөвлөлт</i>	106
4.2.3	<i>Нөөц бололцоог дайчлах</i>	119
4.2.4	<i>Харилцаа холбооны төлөвлөлт</i>	124
4.3	Дайчилгааны үйл ажиллагаа болон олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх оролцооны хэрэгсэл	126
4.3.1	<i>Удирдагч болон гишүүдийн чадавхийг бэхжүүлэх</i>	126
4.3.2	<i>Сүлжээг бий болгох</i>	134
4.3.3	<i>Нөлөөлөл</i>	146
4.3.4	<i>Олон нийт удирдсан хяналт</i>	156
4.3.5	<i>Оролцооны үнэлгээ</i>	158
	Олон нийтийн оролцоонд зориулсан 4-р хэсэг дэх хэрэгслүүдийн эмхэтгэл.	163
	Тэмдэглэл	165
	Ишлэл	173



## Өмнөх үг

2016 оны сүүлээр АПКАСО Сүрьеэд өртсөн хүмүүс болон сүрьеэгийн эсрэг иргэний нийгмийг хамарсан бүс нутгийн хэмжээний нөлөөллийг дайчлах зайлшгүй шаардлагатайг олж харснаар Ази Номхон далайн бүс нутагт “Сүрьеэгийн эсрэг идэвхтнүүдийн эвслийг” (АКТ! АП) байгуулсан юм. Тэр үед сүрьеэд өртсөн хүмүүс, иргэний нийгмийн байдал эрс өөр байв— нөлөөллийн ажлын санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэхэд нэн бэрх, сүрьеэд өртсөн олон нийт харилцан тэгш эрхтэй түнш биш, харин ч хөтөлбөр, үйлчилгээ авах үүргээ бараг үргэлж шахуу шилжүүлж өгдөг байв. Тус бүс нутгийн зарим улс орнуудад сүрьеэгийн дэмжих бүлгүүд байсан хэдий ч, нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн болон үндэсний сүрьеэгийн сүлжээ хязгаарлагдмал байв. Ийм үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын чадавхи, итгэл үнэмшил, дэмжлэг авах боломж бодлогод нөлөөлөх чадавхи тун хязгаарлагдмал байсан юм. АПКАСО болон бидний улс орнууд дахь түншүүд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг өөрчлөх хүчин зүйл нь биоанагаах ухааны давамгайлсан арга барилаас татгалзаж, сүрьеэгээр өвчлөөд эдгэрсэн хүмүүс, сүрьеэд өртсөн олон нийт, иргэний нийгмийн утга учиртай оролцоо, манлайллын орон зайг бий болгох явдал гэдгийг маш сайн мэдэж байсан тул энэхүү нөхцөл байдал нь томоохон сорилтыг бий болгосон юм.

Тухайн үед бид АКТ! АП-ын салбар байгууллагуудтай хамтран АКТ!АП-аар дамжуулан зохицуулалттай, чадавхижсан бүс нутгийн сүрьеэгийн эсрэг олон нийт, идэвхтнүүдийн хөдөлгөөнийг дэмжихээр болсон билээ.

Долоон жилийн дараа өнөөдөр АПКАСО нь бүс нутгийн дотор болон гадна мэдэгдэхүйц эерэг өөрчлөлтүүдийг авчирсан гэрч болж байгаадаа баяртай байна. АКТ! АП улс орны хэмжээнд сүрьеэгийн эсрэг бүс нутгийн эвсэл болон байгуулагдсан билээ. Иргэний нийгмийн сүлжээнүүд бий болж, үргэлжлэн хөгжиж, нөөц болон шийдвэр гаргах орон зайд бүр хүртээмжтэй болж байна.

АПКАСО болон АКТ! АП эдгээр ололт амжилтыг зөвхөн өөрсдийн хүчин чармайлттай холбон хэзээ ч тайлбарлахгүй, тэгвэл үнэнд нийцэхгүй. Гэхдээ бид улс орон, бүс нутаг, дэлхийн түвшинд хувь нэмрээ оруулж буй хүмүүсийн хамтын олон нийтийн салшгүй гишүүн болсондоо баяртай байдаг, бахархаж байдаг. Тэрчлэн АКТ! АП -ыг зохион байгуулдаг АПКАСО нь энэхүү гарын авлагыг бүс нутагтаа оруулж буй бас нэгэн хувь нэмэр болно хэмээн баяртай байгаад зогсохгүй, сүрьеэгийн эсрэг хийх тэмцэлд олон нийтийг дайчлах, улам бэхжүүлэх, иргэний нийгмээс хийх сурталчилгаа, идэвхэд нөлөөлнө хэмээн найдаж байна

Энэхүү удирдамж ном нь үндсэндээ Глобал Сангийн Олон нийт, Эрх, Жендэрийн Стратегийн Санаачилга (CRG SI)-ийн дэмжлэгтэйгээр сүрьеэтэй тэмцэх олон нийтийн чадавхийг бэхжүүлэх гурван жилийн хөтөлбөрийн хүрээнд KHANA (Камбож), Stop TB Partnership (Индонези), APLHIV (Пакистан), Trisuli Plus (Балба), SCDI (Вьетнам) зэрэг байгууллагуудтай хамтран ажилласнаар олж авсан туршлага дээр үндэслэсэн болно. Энэхүү ном нь бидний хамтын хувь бүтээл юм.

АПКАСО болон АКТ! АП-ын хувьд энэхүү гарын авлагын тусламжтайгаар олон нийт, иргэний нийгэм нь сүрьеэтэй тэмцэхдээ хамгийн чухал, тэгш эрхтэй оролцогчид болж, сүрьеэтэй тэмцэх тогтсон ойлголт практикийг бүрмөсөн өөрчилнө гэдэгт найдаж байна. Бидний зорилго нь зүгээр оролцох, тогтсон дүрмийг баримтлах нь хангалтгүй, харин ч шаардлагатай үед эсэргүүцэх, зөрчих, дүрэм, стратегийг дахин тодорхойлох, ерөнхий хандлагыг сайжруулахад оршино.

**РД Марте**

Гүйцэтгэх захирал  
АПКАСО

## Талархал

ЭНЭХҮҮ олон нийтийн оролцооны удирдамж номонд тухайн бүс нутгийн хүмүүс сүрьеэд өртсөн, зовж шаналсан, олон жилийн турш идэвхтэй тэмцсэн, эдгэрч эрүүлжсэн хамгийн шилдэг практик, туршлага, сургамж, хичээлийн хамгийн охь дээж нь багтсан. АКТ! АП болон АПКАСО нь бүс нутагтаа сүрьеэтэй тэмцэх тэмцэлд олон нийтийг гол төв болгож, дэмжих, түүнээ улам баталгаажуулах чиглэлээр тасралтгүй хүчин чармайлт гаргаж байгаад Глобаль Сангийн дэргэдэх Олон Нийтийн Оролцооны Стратегийн Санаачилга (CESI) багт гүн талархлаа илэрхийлж байна.

Манай байгууллагын улс улсын түншүүд болох “APLHIV” (ХДХВ-ийн Халдвартай Хүмүүсийн Нийгэмлэг), Пакистаны Асгар Сатти, Узайр Тарик; KHANA Камбожийн Чоуб Сок Чамреун, Чанторн Фонг; Балбын “ Trisuli Plus” Ачут Ситуала; “SCDI” (Олон Нийтийн Хөгжлийг Дэмжих Санаачилга) Вьетнамын Ву Нгок Хоа; болон “Stop TB Partnership” Индонезийн Теа Хутанамон нарт өөрсдийн түүхийг хуваалцаж, Сүрьеэд өртсөн олон нийтийн дуу хоолойг хүргэж байгаад бид чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. Манай зөвлөх Мария Лени Феликст эдгээр түүхийг чадварлаг эмхэтгэж, удирдамж ном болгон нэгтгэсэнд гүнээ талархаж байна. Энэхүү номыг дэлхий даяар Сүрьеэд өртсөн олон нийт өөрсдийн улс оронд сүрьеэгийн тогтвортой хөдөлгөөнийг бий болгох, оролцооны санаачлагуудыг дэмжих зорилгоор ашиглаж болох юм.

## Товчлол ба нэр томъёо

<b>АКТ! АП</b>	Ази Номхон Далайн Сүрьеэгийн Эсрэг Тэмцэгчдийн Эвсэл
<b>APLHIV</b>	ХДХВ-ийн Халдвартай хүмүүсийн нийгэмлэг
<b>CCM</b>	Үндэсний зохицуулах зөвлөл
<b>CE</b>	Олон нийтийн оролцоо
<b>CESI</b>	Олон нийтийн оролцооны стратегийн санаачлага
<b>CLM</b>	Олон нийт удирдсан хяналт
<b>CLOs</b>	Олон нийт удирдсан байгууллагууд
<b>CRG</b>	Олон нийт, эрх, жендэр
<b>CSOs</b>	Иргэний нийгмийн байгууллагууд
<b>CS</b>	Иргэний нийгэм
<b>CSS</b>	Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх
<b>Глобаль сан</b>	Сүрьеэ, ДОХ, хумхаатай тэмцэх Глобаль сан
<b>KHANA</b>	Кхмер ХДХВ-ДОХ-ын ТББ-ын холбоо – Камбож
<b>SCDI</b>	Олон нийтийн хөгжлийн санаачлагыг дэмжих төв - Вьетнам
<b>STPI</b>	Сүрьеэгийн эсрэг түншлэл Индонез
<b>STP</b>	Сүрьеэгийн эсрэг түншлэл (Stop TB partnership)
<b>Trishuli Plus</b>	Балба дахь Олон нийтийн үйл ажиллагааны бүлэг

## Үндсэн нэр томъёоны товч толь

**Олон нийт:** Энэ нь “нийтлэг шинж чанаруудтай, нийтлэг эрх ашгийнхаа төлөө хамтран ажиллах” сүрьеэд өртсөн нийгмийн дэд бүлгүүдэд хамаарна. (Жишээ нь: газар зүйн нийтлэг байршил, хүйс, нас, соёл, нийгмийн онцлог, эдийн засаг, улс төрийн асуудлууд, хүний эрхийн асуудал гэх зэрэг)

**Олон нийт төвтэй:** Сүрьеэд өртсөн олон нийтийг өөрсдийнх нь хэрэгцээ шаардлага, тулгарсан асуудалтай холбоотойгоор шийдвэр гаргахдаа татан оролцуулна. Үйлчилгээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тэрчлэн сүрээтэй тэмцэх үндэсний стратеги төлөвлөгөөг боловсруулах, үнэлгээ хяналтыг хийхэд тэдний оролцоо зайлшгүй чухал.

**Олон нийтийг хүчирхэгжүүлэх:** Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний хүрээнд сүрээтэй, сүрьеэгээр өвчлөөд эдгэрсэн бүлэг хүмүүс, эмзэг бүлгийн хүн амын бие даасан байдал, өөрийгөө тодорхойлох чадавхийг нэмэгдүүлэх үйл явц үүнд хамаарна.

**Олон нийтийн гишүүд:** Сүрьеэд өртсөн олон нийтийн дэд бүлгүүдэд харьяалагддаг, олон нийтийн байгууллага, сүлжээний нэг хэсэг болгон зохион байгуулалттай эсвэл ямар ч байгууллага, сүлжээнд хараахан хамааралгүй (зохион байгуулалтгүй) хүмүүс үүнд хамаарна.

**Олон нийтийн удирдагчид:** Сүрьеэгийн сүлжээ болон байгууллагуудад албан ёсны манлайллын үүрэг гүйцэтгэдэг эсвэл албан тушаал хашдаг хүмүүс үүнд хамаарна.

**Олон нийтийн оролцоо:** Сүрьеэгээр өвчилсөн, эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгүүд сүрьеэгийн тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход эрх тэгш түншийн хувиар идэвхтэй оролцдог хамтын ажиллагааны үйл явцыг хэлнэ. Тэд

тогтвортой үр дүнд хүрэхэд чиглэсэн төлөвлөлт, хэрэгжилт, нөлөөлөл, хууль эрх зүйн тогтолцоо, бодлого боловсруулах, үйл ажиллагааны удирдамж, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг бүх шатанд шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэрчлэн олон нийтийн оролцоо нь сүрьеэд өртсөн олон нийт хамтаараа тодорхойлсон зорилт бүхий давтагдах үйл явц юм.

**Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ):** Сүрьеэтэй тэмцэхдээ Сүрьеэд өртсөн олон нийттэй хамтран ажилладаг, олон улс, бүс нутаг болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд (жишээ нь, төрийн бус байгууллага, олон нийтэд түшиглэсэн байгууллага, шашин шүтлэгт суурилсан байгууллага, мэргэжлийн холбоод гэх зэрэг) юм.

**Сүрьеэд өртсөн хүмүүс:** Үүнд дархлааны үйл ажиллагаанд нөлөөлдөг биологийн болон зан үйлийн хүчин зүйлсийн улмаас өндөр эрсдэлтэй хүмүүс (жишээлбэл, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, эрүүл бус амьдралын хэв маягтай хүмүүс, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүс); сүрьеэд өртөх өндөр магадлалтай хүмүүс (эрүүл мэндийн ажилтнууд, сүрьеэгийн хавьтал болсон хүмүүс, хоригдож буй хүмүүс, уул уурхайн нөлөөлөлд өртсөн хүн амыг оролцуулан); эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал хүмүүс (ядуу тарчиг нөхцөлд амьдарч буй эмэгтэйчүүд, хүүхдүүд, алслагдсан хүн ам, орон гэргүй хүмүүс, цагаачид, дүрвэгсэд, дотоод дүрвэгсэд, уугуул иргэд, үндэстний цөөнх, биеэ үнэлэгчид, хар тамхи хэрэглэдэг хүмүүс, мөн эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд) гэх зэрэг.

**Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай тогтвортой хөдөлгөөн:** Энэ нь тэдний харилцаа холбоо, сургалтын холболтыг бий болгох, хадгалах, дэмжих чадвар, түүнчлэн хөтөлбөрийг зохицуулах платформ, үйлчилгээ үзүүлэх суваг болох хууль ёсны байдал, хамтын удирдлагатай байгууллага болох үйл ажиллагааг илэрхийлдэг.



## Энэхүү удирдамж номыг хэрхэн ашиглах тухайг

*“Бодлоготой, бие сэтгэлээ бүрэн зориулсан цөөхөн бүлэг хүмүүс  
л бүх дэлхийг өөрчилж чадна гэдэгт хэзээ ч бүү эргэлз; хэрэг  
дээрээ, амжилт авчрах цор ганц зүйл энэ юм шүү.”*

- Маргарет Мид, 1901-1978

### Энэ ном хэнд зориулагдсан вэ?

Энэ удирдамж номыг голчлон сүрьеэд өртсөн олон нийтийн удирдагчид болон гишүүдэд зориулан бүтээсэн бөгөөд сүлжээн дэх тогтвортой хөдөлгөөнийг бий болгоход чиглэсэн оролцооны санаачлагыг хэрэгжүүлэхэд нь туслах зорилготой юм. Олон нийтийн оролцооны үзэл баримтлал, үйл явцыг хэрэгжүүлэхэд сүрьеэд өртсөн хувь хүмүүсийн байр сууринаас ханддаг. Тэдний дуу хоолойг энэхүү номонд оруулсан болно.

Иргэний нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшил, хөгжлийн түншүүдтэй бат бөх түншлэл тогтоохын чухлыг энэхүү номонд онцлон тэмдэглэсэн. Энэхүү онцлох зүйл нь харилцан яриа, бүтээлч үйл ажиллагаан дээр утга учиртай оролцоо цэцэглэдэг гэдгийг хүлээн зөвшөөрч, бат итгэлтэй байгаагаас үүдэлтэй юм. Иймээс энэхүү удирдамж ном нь сүрьеэд өртсөн олон нийтийн сүрьеэг устгах эрхэм зорилгод хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар хамтрагчидаа чиглүүлэхэд зориулагдсан болно.



## Удирдамж ном ямар бүтэцтэй вэ?

Удирдамж номыг дөрвөн хэсэг болгон зохион байгуулж, олон нийтийн оролцооны үзэл бодлыг судалж, үр дүнтэйгээр чиглүүлэх үүднээс хэрэглэгчдэд өгөөжтэй хэлбэрээр толилуулж байна.

**1-р бүлэг:** Олон нийтийн оролцооны нөхцөл байдал, утга учрыг судалж, холбогдох жишээнүүдийн дагуу удирдан чиглүүлэх зарчим, зорилго, үндсэн үнэт зүйлсийг тодорхойлсон. Энэ хэсэг нь олон нийтийн оролцооны талаар илүү гүнзгий ойлголтод болох хүрээг танд олгох зорилготой юм.

**2-р бүлэг:** Сүрьеэд өртсөн хүмүүс, удирдагчид, түншүүдийг хамарсан тоглогчдын үүрэг, хариуцлага, чанарыг тодорхойлно.

**3-р бүлэг:** Бэлтгэл үе, олон нийтийг дайчлах үе, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх үе гэсэн гурван шаттайгаар үйл явц, үйл ажиллагааг удирдан чиглүүлсэн болно.

**4-р бүлэг:** Олон нийтийн оролцоог хангах арга хэрэгслийг хэрхэн ашиглахыг харуулсан. Энэхүү удирдамж номонд өгөгдсөн дасгал, тараах материал, тоглоомуудыг авч үзэхдээ тэдгээр нь сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах нөхцөлд тохируулсан жишээ хэрэглүүр гэдгийг санаарай. Олон нийтийн оролцооны үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл, одоо ашиглаж байгаа хэрэгслүүдийг нэгтгэж хэрэглэж болно. Энэхүү удирдамж номонд дараахь зүйлс багтана:


- Бэлтгэл үе шат, олон нийтийг дайчлах үе шат, бэхжүүлэх үе шат гэсэн гурван үе шаттай хүмүүсийн оролцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх нарийвчилсан **алхмууд**. Тодорхой алхмуудад хамаарах санал болгож буй хэрэгслүүдийг мөн онцлон тэмдэглэв.
- **Интерактив дасгалууд/үйл ажиллагаануудыг** бүлгүүдийн нэг хэсэг болгон зааврын хамт оруулсан болно. Хэрэглэгчдэд хурдан олоход туслах үүднээс

тэдгээр хэрэгслүүдийн хуудсыг удирдамж номын үндсэн бүлгүүдийн тодорхой хэсэгт нарийн зааж өгсөн болно.


- Алхам бүрийг бүтээлчээр гүйцэтгэхэд зориулагдсан **тоглоомууд**. Эдгээр тоглоомын хуудсуудыг хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох үүднээс удирдамж номын үндсэн бүлгүүдийн тодорхой хэсэгт мөн адил зааж өгсөн болно.

Удирдамж номыг судалж байхдаа бүлэг тус бүрийн санаа, үзэл баримтлалыг харуулсан зураг, урлагийн бүтээлүүдтэй таарах болно. Тэдгээр үзүүлэн таниулах хэрэглүүр нь сүрьеэд өртсөн олон нийтийн авах алхмууд, үйл ажиллагааг ойлгох, саадгүй хэрэгжүүлэхэд туслах зорилготой юм.

Нэмэлт агуулга нь ухагдахуун, мэдээллийн эх сурвалжийн ахиу тодруулга, энэхүү номонд ашигласан нэр томъёог тодорхойлсон тайлбар толь, хэрэглүүрийн жагсаалт, лавлагаа зэргийг багтаасан болно.



## Оршил



2021 оны эхээр Ази Номхон Далайн Сүрьеэгийн Эсрэг Тэмцэгчдийн Эвсэл (АКТ! АП) болон АПКАСО нь сүрьеэд өртсөн хүмүүсийн олон нийтийн сүлжээ, байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх иж бүрэн хүчин чармайлтыг санаачилсан. Олон нийт, Эрх, Жендэрийн Стратегийн Санаачлагыг (CRG SI) дэмжихийн тулд Сүрьеэд өртсөн хүмүүс олон нийтийн сүлжээ болон байгууллагуудын урт хугацааны чадавхийг бэхжүүлэх ажлыг эхлүүлсэн юм. Энэ

хугацаанд сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний хүртээмж нь Ковид-19 цар тахлын улмаас хүндрэлтэй тулгарсан. ДЭМБ-ын 2022 оны тайланд өмнөх жилүүдэд гарсан ахиц дэвшил удааширч, зогсонги байдалд орсон эсвэл урвуу байдалтай байсан нь дэлхийн сүрьеэгийн зорилтууд замаасаа алдагдаж, 2021 онд 3 сүрьеэгийн улмаас 1.6 сая хүн нас барсан гэсэн тооцоо гарчээ.

Энэхүү сорилттой нөхцөл байдалтай тулгарсан тул АКТ! АП болон АПКАСО нь сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад үндэсний болон орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоог эрчимтэй, бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулахаас өөр аргагүй болсон. “Хэнийг ч бүү орхи” гэсэн уриа нь дайны үеийн тулааны уриатай адил илүү утга учиртай цуурайтаж байв. Үүний үр дүнд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Олон нийтийн оролцооны Стратегийн Санаачилга (CE SI) төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний тогтвортой хөдөлгөөнийг бий болгох, олон нийтийн чадавхийг бэхжүүлэх зорилготой юм.

Олон нийтийн оролцооны Стратегийн Санаачлагыг (CE SI) улс орны түвшинд хэрэгжүүлсний үр дүн нь утга учиртай оролцоо аажмаар боловч мэдэгдэхүйц нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнд, Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрүүд болон Үндэсний зохицуулах зөвлөл (ҮЗЗ)-д Олон нийт, Эрх, Жендэр (CRG)-ийн асуудлыг нэгтгэх зэрэг багтана. Сүрьеэд өртсөн Олон нийт, Эрх, Жендэр (CRG)-д зориулсан дотоод нөөцийг хамруулах талаар сурталчлах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.

Түнш улс орнуудын олон нийтийн оролцооны санаачлагуудад ажиглагдсан эерэг үр дүнгээс урам авч, АКТ! АП болон АПКАСО нь хөдөлгөөнийг бий болгох хүрээнд үйл явцыг улам боловсронгуй, албан ёсны болгоход чиглэсэн арга хэрэгслийг боловсруулахаар хамтран ажилласан. Энэхүү санаачилга нь “Сүрьеэд Өртсөн Хүмүүс: Олон нийтийн Оролцооны тухай удирдамж ном”-ыг бүтээхэд хүргэсэн юм.

### *Олон нийтийн оролцооны удирдамж номыг хөгжүүлэх нь*

“Олон нийтийн оролцооны тухай удирдамж номны зорилго, зорилт нь түлхүүр, эмзэг, гадуурхагдсан ард иргэдийн эрүүл мэнд, хүний эрх, нийгмийн шударга ёсыг хангах, нөлөөлөл, тогтолцоог сайжруулахад олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудыг нэгтгэж, дэмжих зорилготой бүрэн нийцэж байгаа юм. Энэхүү удирдамж номыг голчлон сүрьеэд өртсөн нийгмийн бүлэг хүмүүсийн удирдагчид, гишүүдэд зориулан бүтээсэн болно.

Тодруулбал, удирдамж ном нь:

- Нийгмийн тухайн бүлэг хүмүүсийн удирдагчид, сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүдэд оролцооны үзэл баримтлал, үйл явцтай холбоотой мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох.
- Олон нийтийн оролцоог хангах санаачлагыг хэрэгжүүлэхэд нийгмийн тухайн бүлэг хүмүүсийн удирдагчдын манлайлах чадавхийг бататган бэхжүүлэх.
- Сүрьеэд өртсөн нийгмийн бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах, тэдний оролцоог төлөвлөх, харилцаа холбоо тогтоох, нөөц боломжийг дайчлах, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, сүлжээ бий болгох, сурталчлах, олон нийтийн оролцооны санаачлагыг хянах, үнэлэх зэрэг практик хэрэгслээр хангах.
- Камбож, Балба, Вьетнам, Индонез, Пакистанд Олон нийтийн оролцооны Стратегийн Санаачлага (CE SI)-ын хэрэгжилтээс сургамж авсан жишээг хуваалцах.
- Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын олон нийтийн оролцооны талаарх мэдлэг мэдээллийг солилцоход дэмжлэг үзүүлэх.



Олон нийт төвтэй, хэрэглэгчдэд ээлтэй байхын тулд энэхүү удирдамж номыг боловсруулахдаа **Оролцооны Аргыг** ашигласан. Олон нийтийн оролцооны Стратегийн Санаачлага (CE SI)-ын түнш таван орны төсөл хэрэгжүүлэгчидтэй зөвлөлдөх уулзалт, гол мэдээлэгчийн ярилцлагыг хийж, номын агуулга, арга зүй, арга хэрэгслийн талаар тэдний санал, зөвлөмжийг цуглуулсан. Нэмэлт санал хүсэлт, ойлголт авах зорилгоор АПКАСО-тай баталгаажуулах уулзалт хийсэн болно. Холбогдох баримт бичиг, хэвлэл, тоглоомуудыг шалгаж, энэхүү номонд оруулахын тулд зохих ёсоор тохируулсан. Хэрэглэгчийн ойлголтыг сайжруулахын тулд интерактив дасгалууд, тоглоомууд болон инфографикуудыг нэгтгэсэн болно.

Удирдамж ном нь үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ.

- 1-р хэсэг.** Сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцооны тухай ойлголттой болох
- 2-р хэсэг.** Олон нийтийн оролцооны тоглогчдын үүрэг, хариуцлага, шинж чанарууд
- 3-р хэсэг.** Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний тогтвортой хөдөлгөөнийг дэмжих олон нийтийн оролцоо: үйл явц ба үйл ажиллагаа
- 4-р хэсэг.** Олон нийтийн оролцоонд зориулсан хэрэгслүүд

# 1-Р ХЭСЭГ

## Сүрьеэтэй тэмцэхэд олон нийтийг татах үзэл санаа,

### ойлголт

Сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоог Зүүн өмнөд Азиас гаралтай, Малайз, Бруней, Сингапур (сепак рага), Индонези (раго), Филиппин (сипа), Тайланд (такрав), Камбож (сек дай), Мьянмар (чинлон), Энэтхэг, Пакистан зэрэг Азийн янз бүрийн оронд өргөн дэлгэрсэн уламжлалт багийн спорт болох сепак такрав буюу кик волейбол зэрэг тоглоомтой адил төстэй.

Олон нийтийн оролцоо болон сепак такрав хоёулаа нэгдмэл баг, тодорхой зорилго, тогтсон үйл явц эсвэл механизм, арга хэрэгсэл, арга техник зэрэг үндсэн үнэт зүйлсийн хамт тоглоход зориулагдсан бүтцийг хуваалцдаг. Гэсэн хэдий ч, олон нийтийн оролцоо нь сепак такрав тоглоомд мөрддөг тодорхой дүрмээс илүү үндсэн зарчмуудын дагуу явагддаг гэдгийг анхаарах нь чухал. Олон нийтийн оролцоо, Сепак Такрав хоёулаа хатуу баг, тодорхой зорилго, тоглох үйл явц, түүнчлэн оролцоо, үндсэн үнэт зүйлсийн хэрэгсэл, арга техникийг багтаасан тоглох тогтолцоотой байдаг.



## 1.1 Урьдчилсан нөхцөл, утга санаа

Олон нийтийн оролцоог судлахын өмнө сүрьеэд өртсөн нийгмийн тэр бүлэг хүмүүсийн урьдчилсан нөхцөл байдал, утга учрыг хэсэгхэн зуур ч болов, эргэцүүлэн бодох нь чухал юм. Тэд гэж хэн бэ? Сүрьеэгийн нөхцөлд бид гурван өөр бүлгийг тодорхойлж болох юм.<sup>6</sup>

- а. **Дархлааны үйл ажиллагааг бууруулдаг биологийн болон зан үйлийн хүчин зүйлээс шалтгаалж сүрьеэгийн эрсдэл өндөртэй хүмүүс** (жишээлбэл, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, ужиг өвчтэй хүмүүс, эрүүл бус амьдралын хэв маягтай хүмүүс, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүс).
- б. **Амьдралын болон ажлын нөхцлөөс хамааран сүрьеэд өртөх өндөр магадлалтай хүмүүс** (жишээлбэл, эрүүл мэндийн ажилтнууд, сүрьеэгийн хавьтал болсон хүмүүс, хоригдож байгаа хүмүүс, уул уурхайн нөлөөлөлд өртсөн бүс нутагт амьдардаг хүмүүс, хэт ачаалалтай эсвэл агааржуулалт муутай байранд байдаг хүмүүс).
- в. **Хүйс, газарзүйн байршил, хөдөлгөөний хязгаарлагдмал байдал, эрх зүйн байдал, гутаан доромжлол зэрэг хүчин зүйлсийн улмаас эрүүл мэндийн үйлчилгээ авахад бэрхшээл тулгарсан хүмүүс** (жишээлбэл, ядуу орчинд амьдарч буй эмэгтэйчүүд, хүүхдүүд, алслагдсан хүн ам, орон гэргүй хүмүүс, цагаачид, дүрвэгсэд, дотоод дүрвэгсэд, уугуул иргэд, үндэстний цөөнх, биеэ үнэлэгч, бэлгийн наймааны хохирогчид, мансууруулах бодис хэрэглэгчид, ижил хүйстэнтэйгээ бэлгийн хавьталд ордог эрчүүд).





“Олон нийтийн оролцоо гэж юу вэ? Бид сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг хамруулах гэж оролдоход зарим нь, “Бидний гол зорилго бол эмчилгээнд хамрагдах. Бидний гол санаа зовж байгаа зүйл бол эмчилгээ хийлгэх, сүрьеэгийн талаар мэдээлэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сонирхохгүй байна” гэнэ. Эсвэл “Би завгүй байна, мөнгө олох хэрэгтэй. Гэр бүлээ тэжээх хэрэгтэй” гэнэ. Мөн зарим нь, “Бид боловсролгүй учраас сүрьеэгийн дугуйлан зохион байгуулж, сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах талаар ухуулга явуулъя гэсэн ч мэдлэг, ур чадвар дутмаг байна” гэнэ.

Одоо сүрьеэтэй зарим хүмүүс сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад олон нийтийн оролцооны талаар юу хэлэхийг харцгаая:

*Манай дүүрэгт сүрьеэгээр өвчилсөн хүмүүст зориулсан хэлэлцүүлэг зохион байгуулдаг гэдгийг би мэдээгүй.*

*Би эхэндээ ийм үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд зориулагдсан байдаг, над шиг сүрьеэгийн өвчтөнд зориулагдаагүй гэж боддог байсан.*

*Сүрьеэтэй тэмцэх байгууллагын төлөөлөгч хэлэхдээ, “Бид хяналтын үйл ажиллагаа нь утга учиртай, сонирхолтой тул үүнд оролцох хүсэлтэй байна.”*

*Сүрьеэгээр өвчилсөн нэг эмэгтэй анхнаасаа сүрьеэгийн байгууллагад элсэх эсвэл сүрьеэтэй тэмцэх аянд оролцохоос татгалзсан, учир нь тэр ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос эмээж байснаа хуваалцжээ. Гэсэн хэдий ч, сүрьеэгийн эсрэг тэмцэхэд идэвхтэй оролцох нь гутаан доромжлол, ялгаварлан гадуурхахтай тэмцэх хүчирхэг хэрэгсэл болдог гэдгийг хожим ойлгожээ.*

Эдгээр хариу үйлдэл нь 2021 онд 20 улс, түүний дотор Азийн 6 улсыг хамарсан Олон нийт, Эрх, Жендэрийн Стратегийн Санаачлагын (CRG SI) үнэлгээнд илэрсэн зөрүүг онцолж байна.





### Сүрьеэд өртсөн нийгмийн бүлгийн оролцоотой холбоотой 2021 оны Олон нийт, Эрх, Жендэрийн (CRG) үнэлгээний үр дүнг судалжгаая:

- Үнэлгээнд хамрагдсан 20 орны дийлэнх нь сүрьеэгийн эсрэг үндэсний хариу арга хэмжээ авахад сүрьеэд өртсөн хүмүүс, түүнчлэн түлхүүр, эмзэг бүлгийн хүн амыг дайчлах, чухал ач холбогдолтой оролцоо дутмаг байгааг тогтоосон.
- Дөрвөн орны шинжилгээнд сүрьеэгийн халдвартай иргэдийн оролцоог огт авч үзээгүй.
- Үнэлгээнд хамрагдсан улс орнуудын 16-д сүрьеэтэй холбоотой бусад асуудлуудтай харьцуулахад сүрьеэгийн хариу арга хэмжээнд сүрьеэд өртсөн иргэдийн оролцооны талаар хангалттай яриа байгаагүй.
- Судалгааны үр дүнд сүрьеэд өртсөн иргэдийн оролцоог үнэлдэг 16 орны 10-д нь сүрьеэгийн асуудалд зориулсан иргэний нийгэм, олон нийтийн бүлгүүд ховор байгааг онцолжээ. Эдгээр бүлгүүд нөлөөллийн хязгаарлалттай тулгарсан бөгөөд санхүүгийн болон бусад дэмжлэгийг хязгаарласан нь сүрьеэгийн эсрэг тэмцэхэд идэвхтэй хувь нэмэр оруулахад саад болж байв.
- Үнэлгээгээр 8 оронд Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүд, сүрьеэтэй тэмцэх бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэхэд сүрьеэд өртсөн хүмүүсийг бодитойгоор татан оролцуулахад хангалтгүй байсан нь тогтоогдсон.
- Хоёр улсад хийсэн үнэлгээгээр сүрьеэд өртсөн олон нийтийн оролцоог бодитойгоор хэрэгжүүлэхэд саад болж буй хууль тогтоомж, бодлогын хийдэл, саад бэрхшээлийг илрүүлсэн. Эдгээр хийдэл сүрьеэ өвчнөөр өвчилсөн хүмүүсийн эрүүл мэндийн шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж байхгүй байсантай холбоотой.



Сүрьеэд өртсөн хүмүүсийг үр дүнтэй хамруулж чадаагүйтэй холбоотой эдгээр санал хүсэлтийг олж мэдсэнээр сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад олон нийтийн оролцоо яагаад хэрэгжихэд илүү хэцүү байдаг талаар эргэцүүлэн бодоход хүргэж байна. Энэ нь мөн “Сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоонд саад болж буй бэрхшээл юу вэ?” гэсэн асуултад хүргэдэг. Нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн саад бэрхшээлүүдийн зарим нь:

- **Мэдлэг, ойлголт дутмаг:** Сүрьеэд өртсөн тухайн нийгмийн бүх гишүүд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээнд оролцохын утга учир, ач холбогдлын талаар хангалттай мэдээлэл, мэдлэгтэй байдаггүй.
- **Хүний эрх ба жендэртэй холбоотой саад бэрхшээлүүд:** Эдгээрт голчлон гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь жендэртэй холбоотой эрсдэл, сүрьеэгээр өвчилсөн хүмүүст тулгардаг шийтгэлийн хууль тогтоомж, бодлого, нийгэмд шударга ёс, хариуцлагын механизмын хүртээмжгүй байдал зэрэг орно.
- **Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулах чадавхи дутмаг:** Энэ нь сүрьеэд өртсөн иргэдийн институци, зохион байгуулалт, манлайлал, удирдлагын чадавхи хангалтгүй байгаатай холбоотой юм.

- **Харилцаа, холбооны бэрхшээл** нь сүрьеэд өртсөн олон нийтийн оролцоо, дайчилгаанд саад учруулдаг. Эдгээр бэрхшээл нь нөлөөллийн болон олон нийтийн дайчилгааны нэр томъёоны талаарх нийтлэг ойлголт дутмаг, харилцааны арга барил дахь соёл, хэл шинжлэлийн ялгаатай байх (хэл яриа, дүрслэл, жишээ хүн бүгдэд нийцэхгүй), Сүрьеэд өртсөн хүмүүст хамааралгүй байх, харилцааны зохисгүй сувгууд зэрэг багтана.
- **Нөөцийн дутагдал.** Тухайн нийгмийн бүлгүүдийн удирдагчид болон байгууллагууд санхүү, хүний болон биений хүчний нөөцийн дутагдалтай тулгардаг нь олон нийтийн оролцоонд үр дүнтэй харилцахад саад болдог. Олон нийтийн тогтолцоог хөгжүүлэх нь чухал хэдий ч хандивлагчид, түншүүд, засгийн газрын хөрөнгө оруулалт дутагддаг.
- **Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс.** Сүрьеэд өртсөн олон хүмүүст олон нийтийн янз бүрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход шаардагдах санхүүгийн хэрэгсэл, нөөц бололцоо, цаг хугацаа дутагддаг.
- **Сүрьеэтэй болон сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс байгууллагын гишүүнчлэлээ хадгалах, эмзэг бүлэгт хүрч ажиллахад өөр бусад ч бэрхшээл учирдаг.** Сүрьеэгийн эмчилгээ дууссаны дараа зарим хүмүүс нөлөөллийн болон олон нийтийн идэвхтэй үйл ажиллагаанаас хойргошиж, сүрьеэд өртөгсдийн цуглаан зэрэгт, оролцох сонирхолгүй болдог. Цагаачид, бичиг баримтгүй хүмүүс, хоригдлууд гэх зэрэг эмзэг бүлэгт хүрч ажиллахад нь олон нийтийн удирдагчдад сайн мэдэхгүй байж болох тодорхой өөр зохион байгуулалт, дайчлах стратеги шаардагддаг, энэ ч бэрхшээл учруулдаг.

Эдгээр саад бэрхшээл нь үндэсний болон орон нутгийн аль алинд нь сүрьеэд өртсөн хүмүүсийн оролцоог бодитойгоор хангахгүй байх нөхцөл шалтгааныг бий болгодог. Сүрьеэгийн стратеги төлөвлөгөө боловсруулах, хөтөлбөрийн үнэлгээнд оролцох, техникийн ажлын хэсэгт хувь нэмрээ оруулах, нөөц бололцоогоо дайчлах, сурталчлах, шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих, судалгаа хийх, сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тэдний оролцоо хангалтгүй хэвээр байна.

Олон нийтийн оролцоо нь асар том сорилт боловч, “сүрьеэгийн тусламж үйлчилгээний хүртээмж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, 2030 он гэхэд сүрьеэг устгах ахиц дэвшлийг хурдасгахад” тун чухал, түлхэц өгөх хүч болж байгаа нь эргэлзээгүй.


**Энэхүү номонд сүрьеэтэй болон сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийнхэн сүрьеэгийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход эрх тэгш түншийн хувиар идэвхтэй оролцдог үйл явц хэмээн олон нийтийн оролцоог тодорхойлсон юм.** Ингэснээр тогтвортой үр дүнд хүрэхэд чиглэсэн төлөвлөлт, хэрэгжилт, сурталчилгаа, хууль эрх зүйн болон бодлогын тогтолцоог боловсруулах, үйл ажиллагааны удирдамж, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг бүхий л хүрээнд шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн олон нийтийн оролцоо нь Сүрьеэд өртсөн олон нийтийн хамтын хүчээр тодорхойлсон зорилтуудад зангилагдсан давтагдах үйл явц хэмээн ойлгож болно.

Энэхүү тодорхойлолтод тусгагдсан олон нийтийн үр дүнтэй оролцооны чухал элемент нь дараах зүйлсийг агуулна.

- Утга учиртай оролцоо
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, эмчилгээний хүртээмж, дагаж мөрдөх байдал сайжирсан, эсэх
- Хүчирхэгжилт, өөрийн болгох
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээнд оролцох зайлшгүй шаардлагатай талаарх ойлголт дутмаг, олон нийтийн оролцооны хязгаарлагдмал чадавх, нөөцийн дутагдал, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалттай холбоотой асуудлууд зэрэг саад бэрхшээлийг даван туулах.



Олон нийтийн оролцооны тодорхойлолтын гол цөм нь сүрьеэтэй, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийнхэн зэрэг хүн амын томоохон оролцоонд хамрагдах эрх юм.



### Сүрьеэгээр өвдсөн хүмүүсийн эрхийн тунхаглалын 21 дүгээр зүйл

**Оролцох эрх.** Сүрьеэгээр өвдсөн хүмүүс төрийн үйл хэрэгт шууд болон өөрийн байгууллага, сонгогдсон төлөөлөөрөө дамжуулан оролцох эрхтэй. Үүнд, сүрьеэтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, журам, заавар, төсөв, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлгээ өгөх бүхий л үйл явц, механизмд идэвхтэй оролцох эрх хамаарна. Энэ эрх нь засаглалын бүх түвшинд сүрьеэгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сүрьеэгийн талаархи эмнэлгийн судалгаанд хамаарна. Төр засаг, олон улсын байгууллага, уугуул иргэд, иргэний нийгмийн байгууллагууд дэмжлэг үзүүлж, шаардлагатай бол утга учиртай, үр дүнтэй оролцоог хангахын тулд боломжийн орон байраар хангах ёстой.


## 1.2 Зорилго

Сепак такрау-д тоглогчид бөмбөгийг тороор дамжуулж, өрсөлдөгчийнхөө талбай руу цохиж оноо авах зорилготой байдаг, эцсийн зорилго нь тоглолтонд ялах явдал юм. Үүний нэгэн адил сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоо тодорхой зорилгод тулгуурладаг. Хэрэв та сүрьеэд өртсөн нийгмийн бүлгүүдийн удирдагчидтай хамтран ажиллах зорилгынхоо талаар ярилцах гэвэл тэдний ихэнх нь дараах зүйлийг илэрхийлэх болно.

“Бид сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай тогтвортой хөдөлгөөнийг бий болгож, чадавхийг нь нэмэгдүүлэхийг зорьж байна. Олон нийтийн оролцоогоор дамжуулан эдгээр зорилгод хүрснээр 2030 он гэхэд сүрьеэгийн эсрэг тэмцэлд үндэсний болон орон нутгийн түвшинд идэвхтэй хувь нэмэр оруулах боломжтой.”<sup>18</sup>

Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн зохион байгуулалтыг бий болгох нь яагаад чухал вэ? Яагаад олон нийтийн оролцооны чухал зорилт болдог вэ?


Манай нийгмийн бүлгийн олон удирдагчид, оролцоог чиглүүлэгчид энэ зорилтыг сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх (CSS) үе шаттай салшгүй холбоотой гэж үздэг. Тэдний үзэж байгаагаар, сүрьеэд өртсөн иргэдийн дунд мэдээлэлтэй, чадвартай, олон нийтэд түшиглэсэн байгууллага, бүлэг, бүтцийг орон нутгийн тогтолцоог бэхжүүлэх үе шатаар дамжуулан хөгжүүлж, хүчирхэг сүлжээг бий болгоход хувь нэмрээ оруулах боломжтой.



Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай, тогтвортой, нэгдсэн зохион байгуулалтыг бий болгохын тулд тэдний хүсэл эрмэлзэл нь дараах зүйлийг хийж чадна гэдгээс үүдэлтэй:

- **Сүрьеэгийн тусламж үйлчилгээг илүү өндөр түвшинд сайжруулах талаар мэдээлж сурталчилж сүрьеэд өртсөн орон нутгийн жижиг байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлнэ.**  
Сүлжээгээр дамжуулан харилцаа холбоо тогтоосноор сүрьеэтэй болон, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийнхний сайн сайхан байдал, таатай орчныг хамтран бүрдүүлж байгаа тул зорилгодоо хүрэх боломж нэмэгддэг. Энэхүү хамтын арга нь сүрьеэтэй тэмцэх үр дүнтэй туршлагыг өргөжүүлэх зэрэг мэдлэг, инновацыг хуваалцахад дэмжлэг болдог.
- Хөтөлбөр, үйл ажиллагааныхаа тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулах **нөөцийг шуурхай дайчилж**, бие даасан байгууллага, сүлжээг тасралтгүй ажиллуулна. Энэ нь эргээд бие даасан байдлыг бий болгож, гадны санхүүжилтээс хараат байхыг бууруулж чадна.
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахтай холбоотой олон нийтийн оролцооны үр дүнтэй туршлага, арга хэрэгсэл, өгөгдлийг түгээн дэлгэрүүлэх, сургалтын солилцоог хөхүүлэн дэмжих, **харилцан уялдаа холбоо, дэмжлэг үзүүлэх соёлыг төлөвшүүлэх.**
- Үндэсний болон орон нутгийн түвшинд утга учиртай оролцоог дэмжих **чадавхитай бүтэц, зохион байгуулалтын дэд бүтцийг бий болгоход туслах.**





Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн зохион байгуулалтын үндэс нь дараах дөрвөн нөхцлийг бий болгох, дэмжих, тогтворжуулах чадварт суурилдаг:

- а. Сүрьеэд өртөгсдийн бүлэг, байгууллагуудын хооронд ижил төстэй хөтөлбөрүүдтэй харилцах, мэдлэг солилцоход туслах холбоосууд;
- б. Хамтарсан бодлого, хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд сүрьеэд өртсөн хүмүүсийн янз бүрийн бүлэг, байгууллагуудын хөтөлбөр, үйл ажиллагаа, нөөцийг зохицуулах платформууд;
- в. Сүрьеэд өртсөн олон нийт, эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн сүрьеэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхтэй холбоотой бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хариуцлагатай, зардал багатай байгууллага Засгийн газар болон хандивлагчдад байх;
- г. Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах хөтөлбөрүүдийн уялдаа холбоотой хэрэгжилт, шинжилгээ, үнэлгээнд хяналт тавих хамтын удирдлагатай байгууллагууд.

Сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн зохион байгуулалтыг бий болгох нь олон нийтийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилготой нягт холбоотой. Сүрьеэд өртсөн олон нийтийн хувьд, **эрх мэдлийг нэмэгдүүлэх** нь юу гэсэн үг вэ? Тэдний хувьд, энэ нь сүрьеэтэй, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс болон эмзэг бүлгийн хүн амд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээнд бие даасан, өөрийгөө тодорхойлох чадварыг нэмэгдүүлэх үйл явцыг илэрхийлдэг. Тэдний эрх мэдлийг нэмэгдүүлэх нь сүрьеэд өртсөн хүмүүсийн дунд манлайлах ур чадварыг хөгжүүлж, нийгэмд бие даах чадварыг нь хөгжүүлэх, тэдний амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах боломжийг олгодог тасралтгүй үйл явц гэж үздэг.

Сүрьеэд өртсөн олон нийтийн боломж боллоцоог өргөтгөх онцлог хэдэн зүйлийг энд дурдъя:

- Үндэсний болон орон нутгийн түвшинд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний нөөц, шийдвэр, үйл явц дахь олон нийтийн хяналтыг сайжруулсан.
- Сүрьеэгийн тархалтын талаарх ойлголт, түүнчлэн сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний хүрээнд хувь хүний эрх, үүргийн талаарх ойлголт сайжирсан.
- Хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой бодлого, хөтөлбөрийн асуудлаар яриа хэлэлцээ хийх, сурталчлах боломж, чадавхи.




- Сүрьеэд өртсөн олон нийтийн доторх олон нийт удирдсан байгууллага, сүлжээнүүдээс бүрдсэн тогтвортой хөдөлгөөнүүд оршин тогтносон.
- Хөтөлбөрийг хамтдаа тусгах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх чадвар.
- Бодлого боловсруулах үйл явцад нөлөөлөхөд чиглэсэн нөлөөлөл, олон нийтийг дайчлах үйл ажиллагаанд манлайлах.
- Сүрьеэгийн оролцогч талуудтай харилцах явцад бие даасан байдал, эерэг бие даасан үзэл баримтлалыг нэмэгдүүлсэн.
- Сүрьеэтэй тэмцэх ажилд олон нийтийг татан оролцуулах үйл ажиллагаанд хүлээх хариуцлага.
- Сүрьеэгийн олон нийтийн төлөөлөгчөөр ажилладаг, чадварлаг, чин сэтгэлтэй олон нийтийн удирдагчдын нөөцтэй болох.

### 1.3 Үндсэн зарчмууд

Олон нийтийн оролцооны чухал тал бол түүний үйл явц, үйл ажиллагааг зохицуулдаг зарчмуудыг дагаж мөрдөх явдал юм. Ихэнх олон нийтийн удирдагчдын онцлон тэмдэглэсэнээр, “сүрьеэгийн халдварт өртсөн хүмүүсийг оролцооны тоглоомын талбайд татах” нь дараах үндсэн зарчмуудыг агуулна<sup>20,21</sup>:

- **Сүрьеэд өртсөн олон нийтийн бүлгүүдийг мэддэг, ойлгодог байх.** Тэдний хаа байгаагаас нь ажлаа эхэл. Тэд гэж хэн бэ, хаана тэд байдаг вэ, тэдэнд тулгарч буй бэрхшээл, тэдний хэрэгцээ юу байдаг вэ, тэднийг хэрхэн яаж татан оролцуулах вэ, тэгж татан оролцуулахад бидний түншүүд хэн болох вэ зэрэг тэдний түүхийн талаархи мэдлэгтэй бай.

- **Сүрьеэд өртсөн олон нийтийг үйл явц, хүчин чармайлтын гол цөмд оролцуулах.** Тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өг. Тэдний бие бялдар, ур чадвар, авъяас чадвар, үр дүнтэй дадлага, шинэчлэл, хүсэл тэмүүллээр дүүрэн оролцооны талбарыг бий болго. Сүрьеэ өвчнийг таслан зогсооход тэднийг чадавхжуулахад анхаарлаа төвлөрүүл.



- **Хүртээмжтэй төлөвлөлт, бэлтгэл зайлшгүй шаардлагатай.** Сүрьеэд өртсөн олон нийтийг татан оролцуулахын тулд бэлэн байдал нэн чухал юм. Төлөвлөлт, бэлтгэл ажлыг хамтран хийж, оролцооны үйл ажиллагаа, арга техник, хэрэгсэл нь хэрэглэгчдэд ээлтэй байх ёстой. Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад оролцож буй олон талын оролцогчдын дуу хоолой, санаа бодлыг сонсох нь маш чухал.
- **Сүрьеэд өртсөн олон нийт, түншүүдтэй итгэлцлийг бий болгож, харилцаа холбоог хөгжүүлэх.** Оролцогчдын дунд ил тод, харилцан ойлголцол, хүндэтгэлтэй байх, аюулгүй орчинг бүрдүүлэх. Оролцох үйл ажиллагааны зорилго, журам, үр дүн нь хэлэлцүүлэгт ил тод, нээлттэй байх ёстой.
- Төрөл бүрийн арга, сувгийг ашиглан оролцогчдын хооронд **тасралтгүй, тууштай харилцаа холбоог хадгалах.**

- Олон нийтийн оролцооны зорилгодоо хүрэхийн тулд **хамтын шийдвэр гаргахад** дэмжлэг үзүүлнэ. Энэ зарчмын гол цөм нь сүрьеэд өртсөн олон нийт болон хамтрагчдын оролцоог хангах, оролцооны соёлыг төлөвшүүлэхэд оршино.
- Олон нийтийн оролцооны амжилт, алдаа дутагдлын талаархи ойлголтын тухай **суралцах сэтгэлгээг өөртөө шингээ.**
- **Сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцооны үр дүн, үр нөлөөг үндэсний болон орон нутгийн түвшинд баярлан тэмдэглэх.** Энэхүү зарчим нь сүрьеэгийн тусламж үйлчилгээний ахиц дэвшлийг нямбай баримтжуулж, үнэлж, хүлээн зөвшөөрч, сүрьеэд өртсөн олон нийт болон бусдад ил тод байлгах боломжийг олгодог.

## 1.4 Үндсэн үнэм зүйл

Үнэт зүйлс нь бидний үйл ажиллагааны үндэс суурь болох үзэл санаа, үндсэн итгэл үнэмшлийг илэрхийлдэг. Сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоо нь түүний үйл явц, үйл ажиллагааг чиглүүлдэг үндсэн үнэт зүйлс дээр суурилдаг. Эдгээр үндсэн үнэт зүйлд **хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг** хангах зэрэг орно.

“Сүрьеэ болон бусад эрүүл мэндийн асуудалд хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй хандах хандлага нь хүний эрх, жендэрийн тэгш байдлын хэм хэмжээ, зарчмуудыг (ялгаварлан гадуурхахгүй байх, эрүүл мэндээ хамгаалах эрх, ил тод байдал, хариуцлагатай байх гэх мэт) хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээнд тусгах. Энэ нь мөн эмзэг бүлэг, түлхүүр хүн амыг чадавхжуулах, тэдний тодорхой эмзэг байдал, хэрэгцээг хангахад шаардлагатай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл тэдэнд хамааралтай

шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог хангах, гомдол гаргах, эрх зөрчигдсэн тохиолдолд хохирлыг барагдуулах механизмыг бий болгох гэсэн үг юм.”

“Сүрьеэд өртсөн хүмүүсийн хүйсийн ялгаа нь жендэрийн онцлогтой ажил мэргэжлийн нөлөөгөөр эрэгтэйчүүдэд илүү их нөлөөлдөг. Эрэгтэйчүүд ажил хөдөлмөртэй холбоотой шилжилт хөдөлгөөнд илүү өртөмтгий байдаг, энэ нь сүрьеэгийн эмчилгээг тасалдуулж болзошгүй юм. Нөгөө талаар, тодорхой нөхцөл байдалд эмэгтэйчүүд сүрьеэгийн үйлчилгээ авахад саад бэрхшээл тулгардаг. Энэ нь гэр бүлийн эрэгтэй гишүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дутуу үнэлдэг гэсэн ойлголттой холбоотой юм. Түүнчлэн эрүүл мэндийн байгууллагад хувийн нууцлал, хүүхэд асрах газар байхгүйгээс эмэгтэйчүүд үйлчилгээ авахаас татгалздаг. Эмэгтэй хоригдлууд хоригдож буй эрчүүдтэй харьцуулахад сүрьеэгийн эмчилгээнд хамрагдах боломж багатай тулгардаг. Цаашилбал, сүрьеэ нь ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн нас баралтын гуравны нэгд хувь нэмэр оруулдаг бөгөөд сүрьеэтэй холбоотой гутаан доромжлол нь ХДХВ-ийн халдвартай холбоотой гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт улам бүр нэмэгддэг<sup>23</sup>.

НҮБ-ын гишүүн орнууд 2023 оны 9-р сарын 22-ны өдөр Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 78-р чуулганаар сүрьеэтэй тэмцэх дээд түвшний уулзалтаар (HLM) Улс төрийн тунхаглалыг албан ёсоор баталсан. Хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг дэмжих амлалт нь дараах гол амлалтуудаас тодорхой харагдаж байна<sup>24</sup>:


- Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын цоорхойг арилгах замаар бүх хүнд хүрч ажиллах.
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг эрх тэгш, хүний эрхэд суурилсан, хүн төвтэй болгож өөрчлөх

- Сүрьеэгийн төгсгөлийг авчрах чухал шинэ арга хэрэгслийг бий болгох ажлыг хурдасгах
- Сүрьеэ өвчнийг зогсооход шаардагдах хөрөнгийг хуваарилах
- НҮБ-с тогтмол тайлагнаж, хянаж байх зэрэг шийдэмгий, хариуцлагатай дэлхийн манлайллын дагуу тууштай ажиллах.

Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад олон нийтийн оролцооны тухай ойлголтыг дэлгэрэнгүй тайлбарласан гарын авлагыг үзэл баримтлалын зураглалын хэрэгслийн хамт 83-р хуудсанд гаргасан.

## 2-Р ХЭСЭГ

### Олон нийтийн оролцооны тогломчдын үүрэг, хариуцлага, чанар



Үүрэг, хариуцлагыг тодорхой тодорхойлох нь олон нийтийн оролцооны үйл явц, үйл ажиллагаанд тоглогч бүрийн оруулсан хувь нэмэр, үүрэг даалгаврыг тодорхой болгож өгдөг тул маш чухал юм. Энэ нь сүрьеэгийн хариу арга хэмжээ болон холбогдох хүлээлтэд тэдний тодорхой үүрэг даалгаварыг тусгасан болно.

Энэ нь “нөлөөлөлд өртсөн гол хүн ам, нийгмийн бүлэг, байгууллага, сүлжээ, олон нийтийн түвшинд иргэний нийгэмтэй хамтран ажиллаж буй эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын үүрэг, оролцоог сайжруулахад чиглэсэн олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх хүрээтэй нийцэж байгаа юм.



Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх (CSS) нь чадавхийг нэмэгдүүлэх, хүний болон санхүүгийн нөөцийг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгдөг. Зорилго нь олон нийт, олон нийтийн тоглогчдыг чадавхжуулах, тэднийг эрүүл мэнд, нийгмийн халамжийн албан ёсны тогтолцооны хажуугаар идэвхтэй, үр дүнтэй хувь нэмэр оруулах боломжийг олгох явдал юм.”<sup>25</sup>

Олон нийтийн оролцоонд чухал тоглогчдын нь сүрьеэд өртсөн олон нийт (сүрьеэтэй өвчтөнүүд, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийнхэн гэх мэт), олон нийтийн удирдагчид багтдаг.

Нэмэлт хувь нэмэр оруулагчид буюу дэмжигч тоглогчид нь сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээнд оролцдог иргэний нийгмийн байгууллагууд, засгийн газрын төлөөлөгчид, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд багтана.

Үндсэн хувь тоглогчид, түншүүд хоёулаа оролцооны үйл явц, үйл ажиллагаанд тодорхой чухал үүрэг, хариуцлагатай байдаг. Олон нийтийн үр дүнтэй оролцооны зайлшгүй хүчин зүйл бол эдгээр тоглогчдын харуулсан чанарууд юм.

## 2.1 Олон нийтийн оролцооны тоглогчдын үүрэг, хариуцлага

Сүрьеэгийн эсрэг тэмцэлд олон нийтийг амжилттай оролцуулах хүчин чармайлтыг багийн чадварлаг тоглогчид үндсэн зарчим, үндсэн үнэт зүйлсээр удирддаг гэдэгтэй олон хүн санал нийлэх байх. Үндсэн тоглогчид, түншүүд тус бүр нь тодорхой үүрэг, хариуцлагыг биелүүлдэг бөгөөд үүнийг дараагийн хуудсанд дэлгэрэнгүй тайлбарласан болно (олон нийтийн оролцоонд тоглогчдын үүрэг, хариуцлагын талаарх чиг баримжаа олгох хэрэгслүүд, үүргийн хүлээлтийн матриц болон Венн диаграммыг 86-р хуудаснаас үзнэ үү).

### 2.1.1 Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд

Өмнө дурьдсанчлан сүрьеэд өртсөн олон нийт, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийн хүн ам багтана. Эдгээр нь сүрьеэгийн эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд булгийн эхтэй адил чухал эх үүсвэр болдог. Зарим гишүүдийн хэлснээр “Сүрьеэгийн хариу арга хэмжээ бидний эргэн тойронд төвлөрсөн бөгөөд бидний оролцоогүйгээр бүрэн дүүрэн биш байна.”<sup>26</sup>



Одоогийн байдлаар сүрьеэд өртсөн хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн олон нийтээс удирдан явуулж буй үйл ажиллагаа нь ихэвчлэн орон нутгийн хамтын олон нийтийн ашиг сонирхолд тулгуурлан бий болсон жижиг, албан бус бүтцийн хүрээнд явагддаг. Цаг хугацаа өнгөрөхөд сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээн дэх тогтвортой нэгдсэн зохион байгуулалт бий болгоход манлайлах үүрэг гүйцэтгэнэ гэсэн хүлээлт байна.

Одоо олон нийтийн оролцоог үр дүнтэй болгохын тулд сүрьеэ туссан өвчтөнүүд, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг

бүлгийнхний хүлээгдэж буй хариуцлагын зарим жишээг авч үзье:

- Сүрьеэгийн талаарх анхан шатны мэдлэг, түүнд тохирсон хариу арга хэмжээ авах
- Сүрьеэтэй тэмцэх байгууллага, сүлжээний гишүүнээр идэвхтэй оролцох
- Өөрийгөө хөгжүүлэх, ялангуяа сүрьеэгийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх ирээдүйн удирдагч болох үйлсэд оролцох
- Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг нэн тэргүүнд тавьж, сүрьеэгийн эмчилгээг дагаж мөрдөх, сүрьеэгийн дахилтаас урьдчилан сэргийлэхэд анхаарах
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад хувь нэмэр оруулах
- Нийгэм, улс төр, хууль эрх зүй, жендэр, эдийн засаг, соёлын хүртээмжийн саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн нөлөөлөл, олон нийтийг дайчлах ажилд оролцох
- Хөтөлбөрийг боловсруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэх, арчилгааны хэрэгжилт, сүрьеэгийн тусламж үйлчилгээний хяналт-

шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголтод хувь нэмрээ оруулах зорилгоор сүрьеэтэй холбоотой амьдралын туршлагыг дэлгэрэнгүй харуулсан мэдээлэл, түүхийг хуваалцаах

- Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд олон нийт удирдсан хяналт тавих
- Сүрьеэд өртсөн хүмүүст үе тэнгийнхний дэмжлэг үзүүлэх
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний янз бүрийн оролцогчдыг урамшуулж, урам зориг өгөх

### 2.1.2 Олон нийтийн удирдагчид

Сүрьеэд өртсөн олон нийтийн дунд бид төлөвшил, хариуцлага, өөрийгөө хүндлэх гүн гүнзгий мэдрэмжээр тодорхойлогддог удирдагчидтай тулгардаг. Эдгээр удирдагчид сүрьеэ өвчин, олон нийтийн оролцоотой холбоотой чухал мэдлэг, ур чадварыг эзэмшсэн бөгөөд сүрьеэд өртсөн олон нийтийг удирдан чиглүүлж, дэмжиж, урам зориг өгч, төлөөлж, тэдний эрх мэдлийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй багийн ахлагчийн үүрэг гүйцэтгэдэг. Бид тэднийг манлайллыг идэвхжүүлэх хүрээнд идэвхжүүлэгч гэж нэрлэдэг.



Олон нийтийн удирдагчдын идэвхжүүлэгч гэж үздэг үндсэн үүрэг хариуцлагад дараахь зүйлс орно:

- **Сүрьеэд өртсөн олон нийтийн шийдвэр гаргах үйл явцыг хөнгөвчлөх.** Манай олон нийтийн удирдагчид идэвхжүүлэгч удирдагч нь дарангуйлагч удирдагчаас ялгаатай гэдгийг ойлгодог.<sup>27</sup> Эхнийх нь сүрьеэд өртсөн олон нийтийн шийдвэр гаргах чадварыг хөгжүүлж, урамшуулахад анхаардаг бол сүүлийнх нь зөвхөн гишүүдийнхээ өмнөөс шийдвэр гаргадаг. Идэвхжүүлэгчид олон нийтийн гишүүдэд чухал шийдвэр гаргахад нь туслахын тулд зөвшилцлийг бий болгодог. Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авч буй олон нийтийн удирдагчид шийдвэр гаргахад үр дүнтэй дэмжлэг үзүүлж байгааг бид хэрхэн батлах вэ? Жишээлбэл, сүрьеэтэй өвчтөн, өвчилөөд эдгэрсэн хүмүүс гутаан доромжлох, гэр бүлийн дэмжлэг дутмаг

байгаатай холбоотой асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Олон нийтийн удирдагчид сүрьеэтэй тэмцэх байгууллага болон түүний гишүүдтэй хамтран дараах үйлдлүүдийг хийж байгаа тохиолдолд энэ асуудлын талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж байгааг бид баталж чадна<sup>28</sup>:

- Сүрьеэгээр өвдсөн олон нийт болон байгууллагыг яаралтай шийдвэр гаргах шаардлагатай асуудал, бэрхшээлийг тодруулахад чиглүүлнэ.
- Гэр бүлийн дэмжлэг дутмаг, гутаан доромжлолтой холбоотой асуудлуудыг шийдвэрлэх янз бүрийн хувилбар эсвэл шийдлийг олоход нь тэдэнд тусал.
- Тэдэнд хамгийн тохиромжтой хувилбар эсвэл шийдлийг сонгохыг зөвшөөр.
- Иж бүрэн хэлэлцүүлгийн дараа зөвшилцөлд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг хөнгөвчлөх
- Гишүүдийн зөвшилцсөн хамтын шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд түлхэц өгч, удирдамжаар хангах.
- Сүрьеэд өртсөн иргэдийг олон нийтийн оролцооны зорилгод хүрэхийн тулд хичээнгүйлэн урамшуулах нь Олон нийтийн удирдагчдын бас нэг чухал үүрэг юм.



- **Сүрьеэд өртсөн олон нийт, байгууллагын гишүүдэд урам зориг өгөхийн тулд** олон нийтийн удирдагчдын авч үзэх зарим зөвлөмжийг энд оруулав:

- Сүрьеэд өртсөн олон нийтийн, ялангуяа сүрьеэтэй өвчтөнүүд, өвдөөд эдгэрсэн хүмүүс дунд хамгийн үр дүнтэй урам зориг төрүүлэгчдийг тодорхойлох. Олон нийтийн удирдагчид эдгээр хүмүүсийг өөрсдийн гишүүдээ зорилгодоо хүрэхэд чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах урам зориг өгөхөд татан оролцуулж болно.
  - Олон нийтийн байгууллага, сүрьеэгийн сүлжээний хувьд ач холбогдолтой ажлуудыг хийхдээ итгэлцлийг бий болгож, өөртөө итгэх итгэлийг төлөвшүүлэх
  - Сүрьеэд өртсөн орон нутагт олон нийтийн оролцооны төрөлхийн ур чадвар, туршлагыг ашиглах
  - Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад хүргэсэн хувь хүн болон хамтын хувь нэмрийг үнэлнэх
  - Үндэсний болон орон нутгийн түвшинд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг хэрхэн сайжруулах талаар гишүүдээс санал, жишээ авах
  - Олон нийтийн удирдагчид болон сүрьеэд өртсөн олон нийт, түүнчлэн олон нийтийн байгууллагын гишүүдийн хооронд ил тод, хүндэтгэлтэй харилцах харилцааг хангах
  - Сүрьеэд өртсөн олон нийтэд хувь хүний болон байгууллагын зорилгоо нэгтгэхэд туслах.
- Олон нийт удирдсан байгууллага/сүлжээнд тогтвортой манлайллын соёлыг төлөвшүүлэх нь олон нийтийн удирдагчдын бас нэг чухал үүрэг юм. Энэхүү олон нийтийн удирдагчдын энэ тусгай үүргийн талаар ярихаасаа өмнө “Пассалонгийн ургамал” (1993) номондоо дурдсан Стив Бендер, Фелдер Рашинг нарын холбогдох эшлэлд гүнээ талархаж уншья:

*“Хүмүүс байгалийн зайхалшгийг эзэмшдэггүй, тэд ердөө хэсэгхэн л өөрсөдөө анхаарал тавьдаг. Хэн нэгэнд баяр баясгалан авчирдаг зүйл бүгдэд бас л баяр баясгалан авчрах ёстой.”*

Нэгдүгээрт, энэ ишлэл нь олон нийт удирдсан байгууллагуудын манлайлал нь нэг юм уу цөөн хэдэн хүнээр хязгаарлагдахгүй бөгөөд хувь хүний шинж чанарт төвлөрдөггүй гэдгийг онцолж байна. Энэ нь хамтын ажиллагааны баяр баясгалан, тасралтгүй байдал, олон нийтийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, тогтвортой манлайллын соёлыг хөхүүлэн дэмждэг тасралтгүй үйл явц юм.

Тогтвортой манлайлал нь хамтын манлайлал болон сүрьеэд өртсөн олон нийтийн дунд урт хугацааны шийдвэр гаргах, тууштай ажиллах чадвартай, бүлгийн удирдагчдын боловсон хүчнийг төлөвшүүлэх боломжийг бүрдүүлдэг. Үүнтэй холбогду олон нийтийн оролцооны удирдагчид манлайллыг үргэлжлүүлэх төлөвлөгөө боловсруулж, идэвхтэй хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэд ирээдүйн удирдагчдын чадавхийг тогтмол нэмэгдүүлэх үүрэгтэй юм.

### 2.1.3 Олон нийтийн оролцооны түншүүд

Манай үндсэн хувь нэмэр түншүүд олон нийтийн оролцооны үйл явц, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг эзэмшсэн бол энэ нь дэмжигч түншүүд сүрьеэгийн эсрэг тэмцэхэд хамтран ажиллах үүргээ гүйцэтгэж байгааг харуулж байна. Стоп ТБ Партнершип нь сүрьеэд өртсөн олон нийтийг дэмжихийн ач холбогдлыг дараах илгээлтээр онцлон хүргэж байна:

“Дэлхий нийтээрээ Сүрьеэд өртсөн олон нийттэй харилцах, тэднийг эмчлэх, өвчний эсрэг хүн төвтэй дэлхийн хариу арга хэмжээнд манлайлагч, эрх тэгш түнш байх эрхийг олгох үүрэгтэй. Тэдэнд хүрч ажиллах нь Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын (ТХЗ) амлалтаа биелүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй энэ нь хэнийг ч орхигдуулахгүй байх явдал юм.”<sup>30</sup>

Сүрьеэд өртсөн олон нийтийн түншүүд болон тэдний олон нийтийн оролцоонд гүйцэтгэх үүргийг доор харуулав:

- **Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ):** Энэхүү номын хүрээнд ИНБ-ууд нь олон улсын, бүс нутгийн, орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд (жишээлбэл, төрийн бус байгууллага, олон нийтэд түшиглэсэн байгууллага, итгэл үнэмшилд суурилсан байгууллага, мэргэжлийн холбоо гэх мэт) сүрьеэд өртсөн ард иргэдтэй хамтран өвчинд хариу арга хэмжээ авах.

Одоогийн байдлаар ИНБ-ууд сүрьеэгийн олон нийт удирдсан байгууллагуудтай (ОНУБ) хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог чиглүүлэгчээр ажиллаж байна. Ихэвчлэн тэдний үндсэн үүрэг хариуцлагад дараахь зүйлс орно:

- Байгууллагын хөгжлийн бүс дэх сүрьеэд өртсөн олон нийтийг төлөөлсөн олон нийт удирдсан байгууллагуудад (ОНУБ) техникийн туслалцаа үзүүлэх (тодорхой тойргийг зохион байгуулах, төлөөлөхөд олон нийтэд туслах), нөлөөлөл мөн олон нийт болон нөөцийг дайчлах.
- Олон нийтийн удирдагчдын чадавхийг бэхжүүлэх.
- Засгийн газар, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд, холбогдох ИНБ-уудтай хамтран ажиллаж, хөтөлбөрөө сурталчлах зорилгоор олон нийтийн удирдагчидтай хамтран ажиллах.
- Олон нийтийн оролцооны үйл явц, үйл ажиллагааг хөнгөвчлөхөд шүүгч, дасгалжуулагчаар ажиллах. Тэд олон нийтийн удирдагчид болон тэдний төлөөлөлд үр дүнтэй харилцаа холбоо тогтооход тусалж, тулгарч буй асуудлуудыг тойрсон зөрчилдөөнийг шийдвэрлэхэд тусалдаг.
- Сүрьеэд өртсөн нийгмийн бүлгүүдийг төлөөлж буй олон нийтийн удирдагчид, тухайн олон нийт удирдсан байгууллагуудын хооронд хэлэлцээ хийх буюу зуучлагчийн үүрэг гүйцэтгэх. Тухайлбал,

сүрьеэгийн хөтөлбөрт бодлогын өөрчлөлт оруулах эвсэл байгуулахад орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас дэмжлэг авах.

- Төрийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавьж, засгийн газарт өөрсдийн үүрэг, хариуцлага, амлалтдаа хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ хариуцлага тооцох.
- Шийдвэр гаргагчдад утга учиртай оролцохыг уриалж байна.



- **Засгийн газар.** Засгийн газар, ялангуяа эрүүл мэндийн салбарын удирдлага дор олон нийтийн оролцоог хангах үндэс суурь болж, таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүд болон Төрийн бус байгууллага (ТББ), иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-ын хамтын ажиллагаа нь орон даяар сүрьеэгийн эсрэг үйл ажиллагааг өргөн хүрээнд өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад олон нийтийн оролцооны тайлан харуулж байна. Энэ нь Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрүүд сүрьеэ өвчинд төвлөрсөн бус төрийн бус байгууллага болон бусад ИНБ-уудыг сүрьеэд өртсөн олон нийтийн хэрэгцээг хангах, дэмжлэг үзүүлэх замаар сүрьеэгийн талаар санаачилгадаа оруулахад түлхэц үзүүлэх үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг юм.<sup>31</sup>



Товчхондоо, засгийн газрын үндсэн үүрэг нь дараах зүйлийг агуулна:

- Олон нийтийг үндэсний стратегийн түншийн байр суурийг баримталдаг эрх зүйн болон бодлогын тогтолцоог бий болгох.
  - Олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор санхүүжилтийг сурталчлах, хуваарилах.
- **Хувийн хэвшил.** Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг хувийн хэвшил сүрьеэтэй өвчтөнүүдийн нэлээд хэсэгт нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Хувийн хэвшил нь сүрьеэгийн ачаалал ихтэй олон оронд шинж тэмдэг илэрсэн хүмүүсийн анхны холбоо барих цэг байсаар ирсэн. Азийн зарим оронд өвчтөнүүдийн 70 хүртэлх хувь нь сүрьеэгийн шинж тэмдэг илэрвэл хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж хүсдэг.”<sup>32</sup>

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийнхэнтэй өргөн хүрээтэй харилцан үйлчлэлцдэг тул олон нийтийн оролцоонд тэдний оролцоо зайлшгүй чухал юм. Тэд Сүрьеэд өртсөн олон нийтийн удирдагчид болон олон нийт удирдсан байгууллагууд (ОНУБ) дараах байдлаар дэмжлэг үзүүлж болно:

- Сүрьеэтэй өвчтнүүд болон тэдний гэр бүлийг олон нийтэд сурталчлах, олон нийтийг идэвхжүүлэх янз бүрийн үйл ажиллагаанд оролцохыг дэмжих.
  - Бодлого боловсруулахад хувь нэмэр оруулах үүднээс холбогдох мэдлэгээ хуваалцах.
- Хоёр болон олон талт хандивлагч агентлагууд, НҮБ-ын байгууллагууд, олон улсын ТББ-уудыг багтаасан **хөгжлийн түншүүд** нь олон нийтийн оролцооны үйл ажиллагаанд санхүүжүүлэгч, техникийн туслалцаа үзүүлэх чухал үүргийг гүйцэтгэдэг.
  - Сүрьеэд өртсөн олон нийтийг хандивлагчдын санхүүжүүлсэн үйл ажиллагаа болон хөтөлбөрүүдийг эрэмбэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх зэрэгт эрх тэгш түнш болгон татан оролцуулах замаар жинхэнэ түншлэлийг бий болгох.

- Хөгжлийн түншүүдийн санхүүжилт, техникийн туслалцаа нь сүрьеэд өртсөн олон нийтийн хөтөлбөрүүдийн сайн туршлагад үнэ цэнийг нэмэхэд анхаарах.
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад чухал бөгөөд тогтвортой үр нөлөөг бий болгохын тулд олон нийтээр удирдуулсан байгууллагуудын хүч чадал, чадавхийг ашиглах.
- Хамтын ажиллагааны үйл ажиллагаанд олон нийтээр удирдуулсан хяналтыг хөнгөвчлөх.



## **2.2 Олон нийтийн оролцоотой тоглогчдын чанар чансаа**

Бид олон нийтийн оролцоотой тоглогчдоос ямар чухал чанарыг эрэлхийлэх ёстой вэ? Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний нарийн төвөгтэй байдал, сорилтуудыг харгалзан бид сүрьеэгийн эсрэг ялалт байгуулахын тулд үнэ цэнэтэй чанаруудаар хангагдсан, ирээдүйг харсан тоглогчдыг шаарддаг.<sup>33</sup> Үнэт зүйлд төвлөрсөн, сайн сонсогч, харилцаа тогтоогч, багийн тоглогч, бэлтгэлтэй, чадварлаг харилцах, соёлд мэдрэмтгий байх зэрэг нь олон нийтийн оролцоог үр дүнтэй болгоход туслах гол чанарууд юм (90-р хуудаснаас Чанарын дасгал сонгох).

**Сүрьеэгийн эсрэг тэмцэлд олон нийтийн оролцоонд сайн тоглож болгодог олон талын шинж чанаруудын талаар тустай ойлголтууд:**

- **Үнэт зүйлд төвлөрсөн тоглогч:** Сүрьеэгийн эсрэг тэмцэлд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хамгаалах талаар ойлгож, сурталчилж, хэрэгжүүлдэг.
- **Сайн сонсогч:** Төрөл бүрийн сонирхогч талуудын санаа бодлыг нэг талыг баримтлалгүйгээр сонсох, мэдээллийг шингээх, бүтээлч санал хүсэлт гаргах чадвартай. “Утга учиртай оролцоо нь олон нийт, төлөөлөгчид, сүрьеэтэй эсвэл сүрьеэгээр өвчилөөд эдгэрсэн хүмүүсийг сонсож, тэдний амьдралын туршлагыг ойлгохоос эхэлдэг” гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.
- **Харилцаа үүсгэгч:** Итгэлцэл, ил тод байдлыг дэмжиж, харилцан хүндэтгэлийг төлөвшүүлж, хамтын ажиллагааны аюулгүй орон зайг бий болгож, түншлэлийг бий болгоход “тэвчээртэй байх нь ариун журам” гэж үздэг.
- **Багийн тоглогч:** Нөхцөл байдалд дасан зохицох чадвар шаардсан үед уян хатан байх, үүргээ ухамсарлах, бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй хувь нэмэр оруулах, бүлгийн зорилго, ололт амжилтыг хариуцах, дутагдлынхаа төлөө өөрийгөө хариуцах, багийн гишүүдтэй хамтран ажиллах дуртай, болон бусадтай шинж чанарууд.
- **Бэлтгэгдсэн:** Олон нийтийн оролцооны зорилгодоо хүрэхийн төлөө ажиллах, сорилт бэрхшээлийг даван туулахад бие бялдар, оюун ухаан, сэтгэл санааны хувьд бэлэн байна.

- **Чадвартай харилцах:** Сүрьеэд өртсөн олон нийт, түншүүдтэй үр дүнтэй, зохистой харилцах талаар мэдлэгтэй. Оролцооны бүх хэлбэрийн хувьд тэд санаа, үзэл бодлоо илэрхийлэхдээ бэлэн, ойлгомжтой, шуурхай, товч бөгөөд ёс зүйтэй байдаг.
- **Соёлын мэдрэмжтэй тоглогч:** Сүрьеэд өртсөн олон нийтийн соёлын үүднээс үйл явдал, нөхцөл байдлыг ойлгодог. Гишүүдийн үнэт зүйл, итгэл үнэмшил, хэм хэмжээ, бэлгэдэл, хэл яриа, зан үйлийн эерэг талууд дээр тулгуурладаг.

## 3-Р ХЭСЭГ

# Сүрьеэд өртөгсдийн тогтвортой сүлжээг бий болгоход оролцох олон нийтийн оролцоо: үйл явц, арга хэмжээ

Өмнөх бидний яриа тоглогчдын хүлээгдэж буй үүрэг, хариуцлага, чанарыг хамарсан олон нийтийн оролцоотой холбоотой гол гол санаан дээр төвлөрсөн билээ. Бид сүрьеэд өртсөн олон нийтэд харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн зохион байгуулалт бий болгоход чиглэсэн олон нийтийн оролцооны үйл явц, үйл ажиллагааны талаар судлах болно.<sup>35</sup> Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд, удирдагчид, түншүүд хоорондоо хэрхэн яаж харилцах вэ? Яриагаа цааш үргэлжлүүлэх тохиромжтой асуулт бол энэ юм.



Ийм нэгдсэн хөдөлгөөнийг бий болгох нь АПКАСО -ийн 2021-2030 оны стратеги төлөвлөгөөний гол хэсэг бөгөөд нийгмийн шударга ёсыг дэмжих, эрүүл мэндийн үр дүнг сайжруулах, эрүүл мэндийн тэгш санхүүжилтийг дэмжих зорилгоор “иргэний нийгмийг цуглуулах, дэмжих, бэхжүүлэх, хөгжүүлэх, урамшуулах, дэмжих”-д анхаарлаа хандуулдаг. Зорилго нь олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх шилдэг туршлага, стандартыг бий болгох явдал юм.

АПКАСО-ийн олон нийтийн оролцооны урт хугацааны санаачилга нь олон нийт удирдсан байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, болон бусад түншүүдтэй хамтран сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээнүүдийн харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн хөдөлгөөн бий болгох явдал юм. Энэхүү санаачилга нь дараахь зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг:

- Бодлого, шийдвэр гаргах хэлэлцүүлэгт сүрьеэд өртсөн олон нийтийн **оролцоо, дуу хоолойг** нэмэгдүүлэх, түүнчлэн сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний удирдлага, зохицуулалтыг сайжруулах
- Сүрьеэд өртсөн олон нийтийн үндэсний стратеги, өртөг зардал бүхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд үзүүлэх **нөлөөг** бэхжүүлэх, тэдгээрт хүний эрх, жендэр, олон нийтийн хариу арга хэмжээ болон олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх
- Сүрьеэд өртсөн олон нийтийн үндэсний хөтөлбөрийн хамрах хүрээ, чанарт хяналт тавих, сүрьеэ өвчнийг таслан зогсоох амлалтыг сурталчлах, **боловсруулсан мэдээллийг** суртал ухуулга, хөтөлбөрийн үйл ажиллагаанд ашиглах боломжийг олгох

Энэхүү номонд бид холбогдох үйл ажиллагаатай олон нийтийн оролцооны үйл явцын харилцан уялдаатай гурван үе шатыг санал болгож байна. Эдгээр үе шатууд нь: 1. бэлтгэх үе шат, 2. олон нийтийг дайчлах үе шат, 3. олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх үе шатуудаас бүрдэнэ. Үе

шат бүрийн арга хэрэгсэл, аргачлалын жишээг номын 4-р хэсэгт дэлгэрэнгүй харуулав. АПКАСО-ийн олон нийтийн оролцооны стратегийн санаачилга төсөлд оролцогч орнуудын **ОНУБ** болон ИНБ-ын туршлага нь эдгээр гурван үе шатны бүтцийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан.<sup>36</sup>

### 3.1 Бэлтгэл үе шат

Бэлтгэл үе шат нь үндэсний болон орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоог хангах үндэс суурийг бүрдүүлдэг тул зайлшгүй шаардлагатай. Зарим удирдагчид болон түншүүдийн онцлон тэмдэглэсэнээр, “сүлжээнүүдийн харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн хөдөлгөөн бий болгох нь гишүүдийн стратегийн оролцоо хамаарч, үр дүнтэй бэлтгэлийг шаарддаг болохыг бид хүлээн зөвшөөрөх ёстой.”<sup>37</sup> Энэ үе шатанд хүлээгдэж буй үр дүнд нь дараахь зүйлээс бүрдэнэ: i. бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах, ii. олон нийтийн оролцооны төлөвлөгөө, iii. нөөц бололцоог дайчлах стратеги, болон iv. холбоо харилцааны төлөвлөгөө.

#### 3.1.1 Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах


Сүрьеэд өртсөн олон нийтийг ойлгоход бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах нь чухал юм. Гол санаа нь сүрьеэтэй өвчтөнүүд, сүрьеэгээр өвчилөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийн хүн ам байгаа газраас удирдагч, чиглүүлэгчид ажлаа эхэлдэг. Энэ зарчим нь олон нийтийн оролцооны богино болон урт хугацааны санаачилгад хамаарна.

*Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах* (CP) нь үндэсний болон орон нутгийн түвшинд сонгосон газруудын сүрьеэгийн нөхцөл байдал болон зорилтот бүлгүүдийн талаар шаардлагатай мэдээллийг цуглуулах арга юм. Энэ нь мэдээлэл цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах, бэлтгэхэд оролцооны арга барил, хэрэгслийг ашигладаг.<sup>38, 39</sup>

Олон нийтийн удирдагчид ИНБ-ын түншүүдийн дэмжлэгтэйгээр дараах алхмууд болон үйл ажиллагааг авч үзэж болно:

**Алхам 1: Эдгээр үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд нийгмийн бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах багийг зохион байгуул:**

- Талбайн мэдээлэл цуглуулахад бэлтгэхийн тулд зорилтот бүлгүүдийн талаарх урьдчилсан мэдээлэл цуглуулах зорилгоор хоёрдогч мэдээллийг хянан үзэх
- Зорилтот олон нийтийн гол асуултуудыг тодорхойлох
- Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд тохиромжтой хэрэгслийг сонгох
- Сүрьеэд өртсөн олон нийтийн сонгогдсон гишүүдийн саналыг цуглуулах
- Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах (СР) төлөвлөгөө, хэрэгслийг урьдчилан турших, эцэслэх, багцлах
- Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах (СР) төлөвлөгөөний арга хэрэгсэл, ерөнхий гүйцэтгэлийн талаар багийг сургах





**Алхам 2: Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулах зорилго, механизмын зорилтот бүлгүүдийг бэлтгэ.**

Үйл ажиллагаанууд нь:

- Зорилго, үйл явцын талаар хамтын ойлголт, эзэмшилд байх олон нийтэд чиг баримжаа олгох уулзалт
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багийг дэмжих зорилгоор зорилтот бүлгүүдээс урамшуулж зоригжуулдаг хүмүүсийг тодорхойлох

**Алхам 3: Зорилтот бүлгээс мэдээлэл цуглуул.** Нийгэмд чиглэсэн, бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах (CP) төлөвлөгөөг эцэслэн баталснаар баг нь тойм, ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, зураглал, асуулга зэрэг дагалдах хэрэгслийг багтаасан мэдээлэл цуглуулах зэрэг сонгогдсон арга техникийг ашиглан мэдээлэл цуглуулахад бэлэн боллоо.

Үүнд дараахь зүйлс орно:

- Олон нийтийн гишүүдийн хүн ам зүйн мэдээлэл эсвэл мөн чанар
- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг
- Сүрьеэгийн хариу арга хэмжээний талаархи санал хүсэлт
- Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний талаарх хэрэгцээ, санаа зовоосон асуудал
- Сүрьеэгийн талаарх мэдлэг, хандлага, дадал.
- Олон нийтийн оролцоотой холбоотой түүхэн туршлага
- Олон нийтийн оролцоонд шаардлагатай оролцогч талууд
- Олон нийтийн оролцоонд зориулсан нөөц бололцоо

**Алхам 4: Сүрьеэд өртсөн зорилтот бүлгүүдээс цуглуулсан мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, баталгаажуулах.** Мэдээлэл цуглуулж дуусмагц бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах (CP) баг дараахь зүйлийг хийх ёстой:



- Судалгааны асуултууд болон бүлгүүдийн талаар мэдээллийг тохирсон мэдээллийн шаардлагад тулгуурлан мэдээллийг ангилах
- Мэдээллийг баталгаажуулах, зохион байгуулах, хувилгах, нэгтгэх, дүн шинжилгээ хийхэд тохиромжтой хэлбэрт оруулах
- Өгөгдлийн ашигтай, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд боловсруулах бүх аргыг баримтжуулна. Чиг хандлага, шинж чанарыг тодорхойлохын тулд цуглуулсан мэдээллийг урьдчилсан буюу хайгуулын дүн шинжилгээ хийх
- Анхны үр дүнг баталгаажуулахын тулд олон нийтийн түвшний шинжилгээнд оруулах
- Өгөгдлийн шинжилгээний үр дүнг тайлбарлах

**Алхам 5: Бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийг бэлтгэж, эцэслэнэ.** Өгөгдлийн шинжилгээ, баталгаажуулалт дууссаны дараа бүлгүүдийн талаар мэдээллийг цуглуулах багийн дараагийн ажил бол холбогдох бүх мэдээллийг нэгтгэж, гол үр дүнг нэгтгэн дүгнэх явдал юм. Бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийг бүтээлч байдлаар бичиж, танилцуулна.

**Алхам 6: Бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийг түгээх.**

Бүлгүүдийн мэдээллийг цуглуулж дууссаны дараах эцсийн алхам бол сүрьеэд өртсөн орон нутаг, түншүүд болон бусад оролцогч талуудын дунд мэдээллийг хуваалцах, түгээх, хэлэлцэх явдал юм. Олон нийтийн уулзалт зохион байгуулж, Бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийн үр дүнг танилцуулна. Тэдний санал хүсэлт, хариултаар дамжуулан цуглуулсан мэдээллийг улам боловсронгуй болгох болно. Бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийг хуваалцахын тулд бүтээлч, хэрэглэгчдэд ээлтэй хэрэгслүүдийг ашиглана. Мэдээлэл түгээх форум, уулзалт, урлагийн наадам, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд байршуулах зэрэг мэдээлэл солилцож болох зарим үйл ажиллагаа юм.

(Бүлгүүдийн талаарх мэдээллийг цуглуулахад дараах хэрэгслүүдийг 4-р хэсгээс харж болно: а. Хүний зангилаа тоглоом, хуудас.93; б. Надад зураг зур, хуудас.95; в. Сүрьеэгийн талаарх нөөц бололцооны зураглал, хуудас.97;

г. Хэн+Хийдэг тоглоом, хуудас.99; д. Халаасны хүснэгт, хуудас.101; е. Онц ноцтой ослын шинжилгээ, хуудас.104; болон ё. Олон нийтийн мэдээллийн баримтат жишээ хуудас, хуудас.105.)

### 3.1.2 Олон нийтийн оролцооны төлөвлөгөө боловсруулах

Сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн дундах бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийн үр дүн нь төлөвлөлт, стратеги боловсруулахад, ялангуяа олон нийтийг дайчлах, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэнэ. Төлөвлөгөөний боловсруулалт нь итгэлцлийг бий болгох, дэмжлэг авах, санал хүсэлтийг цуглуулахад тусална. Богино болон урт хугацааны хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад санал болгож буй алхмууд нь сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээний тогтвортой нэгдсэн хөдөлгөөнийг бий болгохтой ижил байна.<sup>40</sup>

**Алхам 1: Сүрьеэд өртсөн орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулах төлөвлөлтийн багийг бүрдүүлэх.** Үүнд стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө багтсан болно.

**Алхам 2: Олон нийтийн оролцооны зорилго, зорилтыг тодорхойлох.** Энэ алхам нь Сүрьеэд өртсөн олон нийтийн зорилтот бүлэгтэй харилцах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог. Энэ нь:

- Олон нийтийн оролцооны зорилгын талаар өөрсдийн үзэл бодлыг хуваалцахад олон нийтийн гишүүдийг татан оролцуулах
- Сүрьеэгээр өвдсөн олон нийтийн гишүүдтэй хамтран зорилго, зорилтуудыг тодорхойлох

**Алхам 3: Олон нийтийн оролцооны санаачлагад оролцогч талуудыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх.** Сүрьеэд өртсөн зорилтот бүлгийн гишүүд олон нийтийн оролцоонд оролцогч талуудыг тодорхойлох, тэдний тодорхой сонирхол, хэрэгцээг ойлгох, нөлөөллийн

түвшинг үнэлэх, тэдэнтэй харилцах хамгийн үр дүнтэй арга замыг тодорхойлоход оролцох ёстой.

**Алхам 4: Хамтын ажиллагааны стратегийг**

**тодорхойлох.** Энэ алхам нь стратегийн хэрэгжилтийн цаг хугацаа, харилцааны сувгуудыг зааж өгөх, мэдээлэл өгөх, зөвлөлдөх, татан оролцуулах, хамтран ажиллах, чадавхжуулах зэрэг олон нийтийн оролцооны түвшинг тодорхойлдог. Үүнд олон нийтийг дайчлах тодорхой аргуудыг тодорхойлох, тодорхойлсон бусад гол оролцогч талуудыг татан оролцуулах зэрэг орно. Сүрьеэд өртсөн олон нийтийг дайчлах, оролцогч талуудад, зорилго, зорилтодоо хүрэхэд чухал хувь хүмүүсийг оролцуулах, оролцоог дэмжихэд олон төрлийн арга хэрэгсэл, үйл ажиллагаа шаардлагатай.

**Алхам 5: Олон нийтийн оролцоонд хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсруулах.**

Олон нийтийн оролцоог хангах хяналт, шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) нь зорилго, стратеги, үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Тодруулбал, сүлжээнүүдийн харилцан уялдаатай тогтвортой нэгдсэн хөдөлгөөн бий болгоход чиглэсэн олон нийтийн нэгдсэн зохион байгуулалт, тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ХШҮ-ний хүрээ нь дараах асуултуудыг авч үздэг:

- Олон нийтийн оролцооны үйл явцад юуг хянах вэ?
- Олон нийтийн оролцооны үйл явцад юуг үнэлэх вэ?
- Хяналт, үнэлгээг хэрхэн хийх вэ?
- Хяналт, шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг хэзээ явуулах вэ?
- Хяналт үнэлгээний үйл ажиллагааг хэн явуулах вэ?
- Хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрхэн түгээж, ашиглах вэ?



**Алхам 6: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.**

Энэ нь сүрьеэд өртсөн олон нийтийн удирдагчид, түншүүд, гишүүдийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй стратеги, тодорхойлсон зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тусгадаг. Мөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцогч бүрийн үүрэг, цаг хугацаа, шаардлагатай нөөц, төсөв, ажлын төлөвлөгөөний үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээний төлөвлөгөө зэрэг багтана. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад олон нийтийг дайчлах, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх нь гол зүйл юм.

(Таны олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулахдаа ашиглаж болох дараах хэрэгслүүдийг энэхүү удирдамж номын 4-р хэсэгт заасан болно: а. Ойр дотны газрын зураглал, х.106; б. Олон нийтийн алсын хараатай холбоотой дүрд тоглох, х.108; в. SWOT шинжилгээ, х. 110; г. Найз эсвэл дайсан, Оролцогч талуудын дүн шинжилгээ, х.113; д. Оролцогч талуудын зураглалын жишээ, х.115; е. Үйл ажиллагааны төлөвлөгөөний дасгал, хуудас.116; болон ё. Олон нийтийн оролцооны үйл ажиллагааны төлөвлөгөөний жишээ, х.117. )

### 3.1.3 Нөөц бололцоог дайчлах

Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг боловсруулахын хамт зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоогоо дайчилна.<sup>42</sup> Үүнд үйлчилгээ үзүүлэгчдээс шинэ болон нэмэлт эх үүсвэрийг хангахад чиглэсэн бүхий л үйл ажиллагаа багтана. Тэрчлэн сүрьеэд өртсөн олон нийтийн нөөц бололцоог дайчлах, үр дүнтэй туршлагыг тодорхойлох, нэвтрүүлэх асуудлыг багтаах ёстой. Нөөц бололцоогоо дайчилж, олж авах нь олон нийтийн оролцооны төлөвлөгөө хэрэгжих, тасралтгүй байх, улмаар өргөжих чадварыг баталгаажуулдаг. Энэ нь эргээд олон нийтийн оролцоог хангах нөөц бололцоог бий болгоно, бүтээлч байдал нэмэгдэнэ, чадвар чадавхи сайжирна. Дараах хэдэн алхам, үйл ажиллагаа нөөц бололцоог дайчлахад тусална:

**Алхам 1: Олон нийтийн оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоог дайчлах стратеги боловсруулах.** Сүрьеэд өртсөн олон нийт стратегийг боловсруулахад оролцох ёстой, ялангуяа:

- Нөөцийн зорилтыг тодорхойлох
- Дотоод гадаад нөөц бололцоог тодорхойлох
- Нөөц бололцоо олгогчдын зураглалыг гаргах
- Нөөц бололцоонд хандах механизмыг тодорхойлох
- Нөөц бололцоог зөв ашиглах арга замыг тодорхой болгох

**Алхам 2: Нөөц бололцоог дайчлах багийг бүрдүүлэх**


Энэ бол багийн хүчин чармайлт болох тул сүрьеэд өртсөн олон нийт, олон нийтийн удирдагчид, түншүүдээс аль болох чадварлаг хүмүүсийг багтаах ёстой. Багийн даалгавар нь дараахь зүйлээс бүрдэнэ:

- Нөөц бололцоог дайчлах төлөвлөгөө гаргах
- Нөөц бололцоог дайчлах үйл явцыг удирдах
- Нөөц бололцоог олгогчдын түүхийг судлах
- Нөөц бололцоог олгогчидтой холбоо тогтоох
- Нөөц бололцоог дайчлах төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх
- Нөөц бололцоог дайчлах стратегийг шинэчлэх буюу шинээр боловсруулах

**Алхам 3:** Удирдамж, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизм зэрэг **нөөц бололцоог дайчлах тогтолцоо, журмыг бий болгох.**

**Алхам 4: Нөөц бололцоог дайчлах төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх.** сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд болон тэдний удирдагчид нөөц бололцоог дайчлахын чухлыг хүлээн зөвшөөрөх ёстой. Цаашилбал, олон нийтийн оролцооны бүх тоглогчид нөөц бололцоог тогтвортой дайчлах үйл явцад аль болохоор хичээл зүтгэл гаргаж, тууштай байх ёстой.

(Таны лавлагаа болох нөөц бололцоог дайчлах дараах хэрэгслүүд нь: а. Нөөц бололцоог дайчлах тухай эвлүүлэг, х.119; б. Нөөц бололцоог дайчлах үйл ажиллагааны төлөвлөгөө, х.121; в. төлөвлөгөөний жишээ, х.123; г. Нөөц бололцоог тодорхойлох маягт, нөөц бололцооны тэргүүлэх хэрэгцээ, нөөцийн хэрэгцээ, цоорхойг тодорхойлох, х.123)



### **3.1.4 Харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах**

Олон нийтийн оролцооны санаачлагад оролцож байсан бидний ихэнх хүмүүсийн хувьд үр дүнтэй харилцаа холбоо тогтоох нь цаашдын үйл явц, арга хэмжээнд чухал ач холбогдолтой гэдгийг бид мэднэ. Сүрьеэд өртсөн олон нийт болон бусад оролцогч талуудтай харилцах нь хэзээ ч амар хялбар байдаггүй ч, ихэнхдээ үнэ цэнэтэй байдаг. Олон нийтийн нэгэн удирдагч хэлэхдээ, “Олон нийтийн оролцоо бол харилцаа холбоо юм, учир нь бид сүрьеэгээр өвчилсөн иргэдтэйгээ сайн ярилцаж, тэдний асуудал, тулгамдсан зүйл, хүсэл эрмэлзлийг нь ойлгож,

сүрьеэгийн тусламж үйлчилгээний талаар үнэн зөв мэдээллээр хангах боломжтой болдог. Тэдэнд шаардлагатай тусламж, үйлчилгээ авах эрхийг нь хангах боломжийг олгодог.”<sup>43</sup>

Харилцааны төлөвлөгөөтэй байх нь оролцооны явцад чухал ач холбогдолтой байдаг нь эргэлзээгүй. Үр дүнтэй харилцаа холбоо нь олон нийтийн оролцооны зорилго, зорилтыг бий болгоход тусалдаг. Дараах алхмууд нь харилцааны төлөвлөгөөг боловсруулахад тусална:

**Алхам 1: Харилцааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг удирдан чиглүүлэх багийг бүрдүүлэх.**

Багийн бүрэлдэхүүнд Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүдээс чадварлаг харилцаа холбооны ажилтнууд байх ёстой.

**Алхам 2: Харилцааны төлөвлөгөөг боловсруулахад зорилтот олон нийтийг татан оролцуул.** Тэднийг дараах байдлаар эрх, боломж бололцоогоор өргөтгөнө:

- Төлөвлөгөөний зорилго, зорилт санал болгож буй төсөлдөө тэднийг чиглүүлж өгөх
- Ямар харилцаа холбооны стратегиар хамтран ажиллах талаар хүсэлтийг нь сонсох
- Харилцаа холбооны төлөвлөгөөний төслийнхөө талаар тэдний санал бодлыг асууж, мэдэх

**Алхам 3: Харилцаа холбооны төлөвлөгөөний зорилгыг тодорхой болгож, олон нийтийн оролцооны зорилго, зорилттой нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.** Энэ зорилго нь Сүрьеэд өртсөн олон

нийт, өөр бусад оролцогч талуудтай харилцах контент (мэдээлэл, гол мессеж гэх мэт) бий болгоход чиглэгддэг.

**Алхам 4: Сүрьеэд өртсөн олон нийтийн дунд цуглуулсан бүлгүүдийн талаар мэдээлэл, оролцогч талуудын дүн шинжилгээнд үндэслэн зорилтот бүлэг болон зорилтуудыг тодорхойлох.** Шаардлагатай бол харилцааны зохих зорилтуудыг сонгож, эрэмбэлэхийн тулд нөхцөл байдлын шинжилгээний нэмэлт үйл ажиллагаануудаар мэдээллээ шинэчил.



Зорилтот хүмүүсийг тодорхойлсны дараа тус бүрийн харилцааны зорилгыг тодорхойлох цаг болжээ. Дараах асуултуудыг асууж сүрьеэгийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж байна уу? Та сүрьеэгийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоонд хандах хандлагыг өөрчлөхийг зорьж байна уу? Сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхахын эсрэг хууль батлах зэрэг үйл ажиллагааг идэвхжүүлэхийг хүсэж байна уу?

Зорилтот хүмүүсийг тодорхойлох асуултууд:

- Сүрьеэд өртсөн олон нийт, оролцогч талуудын үндсэн болон хоёрдогч хүмүүс хэн бэ?
- Сүрьеэгийн хариу урвалын талаарх таны мессежийг хэн мэдэх ёстой вэ? Сүрьеэгийн эсрэг тэмцэлд сүрьеэгээр өртсөн хүмүүсийг татан оролцуулахын ач холбогдлын талаар хэн ярьж байна вэ?
- Сүрьеэгийн эсрэг хариу үйлдэл үзүүлэхэд хэн нөлөө үзүүлдэг боловч олон нийтийн оролцоог сонирхдоггүй вэ?

**Алхам 5: Гол санаагаа боловсруулах.** Та ямар чухал зүйлийг хэлэхийг хүсч байна вэ? Тэдгээр мэдээлэл нь тодорхой зорилтот хэрэглэгчдэд тохирсон, шинэлэг, ойлгомжтой байх ёстой.

**Алхам 6: Харилцааны стратегийг бий болгох.** Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд болон гол оролцогч талуудын дунд зорилтот хүмүүстэй харилцах харилцааны зорилгодоо хүрэхийн тулд гол санаагаа хуваалцахдаа та ямар стратеги ашиглах вэ?

Олон нийтийн оролцооны туршлагаас харахад, төрөл бүрийн стратеги бүхий олон талт арга барил нь ялангуяа сүрьеэгээр өвдсөн хүмүүст нөлөөлдөг хүний эрхийн тулгамдсан асуудал, зорилтот бүлгийн талаар арга хэмжээ авахад түлхэц өгдөг

ихээхэн үр дүнтэй болох нь харагдаж байна. Харилцааны стратеги сонгохдоо дараах зөвлөмжийг анхаарна уу.

- Зорилтот бүлгийнхний ашигладаг, илүүд үздэг платформуудыг судлах (жишээлбэл, Facebook гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгсэл)
- Платформыг гол санаатай уялдуулах (Аль гол санаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд илүү тохиромжтой вэ?)
- Зардал багатай стратеги эсвэл өөрийн нөөц бололцоод таарсан стратегиудыг сонго. Сонгосон стратеги нь бага зардлаар харилцааны ихээхэн үр дүнг өгөх үү гэдэгт гол анхаарлаа хандуулах нь чухал.

**Алхам 7: Мэдээлэл сурталчилгаа түгээх ажлын төлөвлөгөө боловсруулах.** Энэ нь Сүрьеэд өртсөн олон нийт болон таны зорьж хүрэх гэсэн гол оролцогчдын дунд гол санаа, үйл ажиллагаагаа хуваалцах, сурталчлах сувгийг шийдэх явдал юм. Төлөвлөгөөнд мөн хувь хүмүүс, байгууллагууд, тогтоосон харилцаа холбоо багтана. Нийгмийн бүлгүүдийн талаарх цуглуулсан мэдээлэл, оролцогч талуудын дүн шинжилгээгээр боломжит түнш болох боломжтой гэж үзэн түгээн дэлгэрүүлэх, таниулах хөшүүрэг болох хүмүүсийг оруулсан байна.

**Алхам 8: Харилцаа холбооны төлөвлөгөөг түгээх цаг хугацаа, төсөв боловсруулах.** Энэ алхам нь дараах зүйлийг тусгасан болно:

- Үйл ажиллагаа бүрийн хуваарь, жишээлбэл, төлөвлөлт, харилцаа холбооны бүтээгдэхүүн бий болгох, түгээх
- Үйл ажиллагаа бүрт үүрэг хариуцлагыг хуваарилах
- Стратеги боловсруулах, түгээн дэлгэрүүлэх төсөв боловсруулах


**Алхам 9: Харилцааны төлөвлөгөөний үр дүнг хянаж, үнэл.** Харилцааны ахиц дэвшил, үр дүнг хэмжих үзүүлэлтүүдийг төлөвлөгөөнд тусгах ёстой. Төлөвлөгөөний үр дүнд хяналт тавих арга барилын нэг болох олон нийтийн хяналтыг ашиглах

(Харилцааны төлөвлөлтийн дараах хэрэгслүүдийг үзнэ үү: а. Санааны самбарын тоглоом, х.124; б. Харилцаа холбооны төлөвлөгөөний загвар, хуудас.125.)

**“Бэлтгэлтэй байх нь чухал!  
Сүрьеэтэй тэмцсэн Балба дах Үндэсний  
зохицуулах зөвлөлийн оролцооны тухай  
сурвалжлага**

“2018 оноос өмнө Балбын Улс Үндэсний зохицуулах зөвлөл (ССМ)” сүрьеэгийн тойргийн төлөөлөгч байгаагүй. Сүрьеэгээр өвчилсөн иргэдэд зориулсан албан ёсны суудал байгаагүй. Эхэндээ бид Тришули Плюс нь сүрьеэтэй харьцуулахад ХДХВ-ийн халдварыг сурталчлах, дайчлах ажилд илүү туршлагатай тул амжилтанд хүрэхгүй гэж бодож байсан юм. Гэхдээ бид бууж өгөөгүй, бид зүгээр л тэр арчаагүй мэдрэмжээсээ салсан” гэж Тришули Плюс компанийн байгууллагын захирал Ачут Ситаула хэлэв.

“2006 онд байгуулагдсан Тришули Плюс нь Балбын олон нийтийн үйл ажиллагааны бүлэг юм. Энэ нь ХДХВ-ийн халдвартай, сүрьеэгийн өвчнөөр өвчилсөн хүмүүсээр удирдуулсан ашгийн бус төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Гол зорилго нь урьдчилан сэргийлэлт, арчилгаа, дэмжлэг, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг. ХДХВ, сүрьеэгийн эсрэг Тришули Плюс нь “амьдралын чанарыг сайжруулах, нийгэм, эрхэд суурилсан зарчимд үндэслэсэн урьдчилан сэргийлэх, дэмжих, эмчлэх арга замаар эрүүл мэндийн үйлчилгээ тэгш хүртээмжтэй байх” эрхэм зорилгыг удирдлага болгодог. Тус байгууллага нь сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг идэвхийлэн дэмжиж, сүрьеэгийн эсрэг тэмцэлд олон нийтийг дайчлах, Балбын нийгэм, эрх, жендэрийн асуудлыг үнэлэхэд оролцдог.”



Энэ нийгэмлэг байгууллагын удирдлагууд нь сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг зохион байгуулахад хүндрэлтэй байгааг олж анзаарсан юм. Өвчтөнүүд эмчилгээгээ дуусгасны дараа олонхи нь өмгөөллийн ажил, дайчилгааны үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцох дургүй байгааг нь олж тогтоов. Зарим нь сүрьеэгээр өвдсөн хүмүүсийн хүрээллээс сураг чимээгүй алга ч болдог байв.

• *“Бидний стратеги бол сүрьеэд өртсөн хүмүүст хүрч ажиллах, тэднийг эгнээндээ элсүүлэх, тогтвортой хамт байх, чадавхийг нь нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах явдал байв. Олон нийтийн оролцооны гол зорилго нь Сүрьеэд өртсөн иргэдээс тойргийнхоо төлөөллийг хангах явдал байлаа. Бид Үндэсний зохицуулах зөвлөл (ҮЗЗ)-тэй хамтран ажиллахаар бэлтгэсэн юм. “Сүрьеэгийн олон нийтийн орчин, түүний чадавхийг үнэлж, ХДХВ-ийн нийгэмлэгээс сүрьеэгээр өвдсөн хүмүүсээс боломжит удирдагчдыг тодорхойлсон. Тришулигийн Эерэг Яригчдын Товчоогоор дамжуулан тэдэнд урам зориг өгч, сургаж, түүх яриулах нь амьдралын туршлагаа хуваалцах чухал хэрэгсэл болдог ҮЗЗ-тэй харилцахад чиглэгдсэн байв. Бэлтгэл ажил ч үр дүнгээ өгч, сүрьеэгээр өвдсөн иргэдээс ҮЗЗ-ны гишүүнтэй боллоо.”*

“Балба дахь Сүрьеэд өртөгсөд бэлтгэл сургуулилт, зохион байгуулалт сайтай байх тусам сүрьеэгийн эсрэг тэмцэлд орон нутгийн болон үндэсний хэмжээнд оролцох боломж нэмэгддэг. Үүнийг бид өөрсдийнхөө туршлагаасаа ойлгосон юм. Тэдний идэвхтэй оролцоо нь ҮЗЗ-ны үйл ажиллагааны гарын авлагыг дүрэмдээ “ҮЗЗ-нд сүрьеэгээр өвдсөн аль эсвэл өвдөөд эдгэрсэн нэг хүн байх ёстой” гэж тодорхой зааж өгсөнд тэд талархалтай байдаг.”

• “Бидний хичээл зүтгэл үр дүнгээ өгч, сүрьеэтэй тэмцэх тойргийн төлөөлөл дүрэм журамд шингэсэн. Хамгийн гайхалтай нь сүрьеэгээр өвдсөн зуу гаруй хүн ҮЗЗ-ны гишүүнээр элсэх хүсэлт гаргасан явдал юм. Бид сүрьеэтэй тэмцэх олон нийтийн удирдагчдыг амжилттай бүрдүүлж чадсан нь сүрьеэгийн эсрэг тэмцлийн нэгэн бахархал мөн болохыг онцлон тэмдэглэж байна.”

“Бэлтгэлтэй байна гэдэг сэтгэл бидний ажлын явцад нэвт шингэсэн байх ёстой.” Энэ бол бидний Непалын Улс орны зохицуулалтын механизмтай хамтран амжилттай явуулсан олон нийтийн оролцооны ажлаасаа олж авсан сургамж юм.

### 3.2 Олон нийтийг дайчлах ажлын үе шат

Өмнөх хэсэгт бид олон нийтийн оролцоонд бэлтгэхийн ач холбогдлыг онцолсон. Та олон нийтийн оролцооны төлөвлөгөө, нөөц болооцоог дайчлах, харилцаа холбооны төлөвлөгөөг боловсруулахад үндэс суурь болох нийгмийн бүлгүүдийн мэдээллийг цуглуулах тухайд ойлголт, зөвлөмж авсан. Оролцох үйл явцад олон нийтийг дайчлах үе шат нь хамтрагчдын дэмжлэгтэйгээр олон нийтийн удирдагчдын удирдсан бэлтгэл ажлын чанарт тулгуурладаг.

Гэхдээ бид олон нийтийн хөдөлгөөнийг эхлүүлэхийн өмнө түүний утгыг ойлгоцгооё. Энэхүү номын хүрээнд **олон нийтийг дайчлах гэдэг нь** сүрьеэд өртсөн олон нийтийн аль болох олон гишүүдийг өөрсдийн сүлжээн дэх тогтвортой хөдөлгөөнийг бий болгоход татан оролцуулах үйл явцыг хэлнэ.<sup>44</sup> **Дайчилгааны арга хэмжээ нь** олон нийтийн оролцоонд тулгуурласан, олон төрлийн оролцооны стратеги, хэрэгслийг ашигладаг.

Бэлтгэлийн үе шатанд үндсэн багийг бүрдүүлэх, олон нийтийн оролцоог төлөвлөх, зорилтот бүлгүүдтэй харилцах ажлыг эхлүүлэх зэрэг олон нийтийг дайчлахаас өмнөх тодорхой ажлуудыг олон нийтийн оролцооны төлөвлөгөөнд нэгтгэсэн болохыг та анзаарах болно.

Бидний хэлэлцүүлэгт дараах асуулт гарч ирнэ: Бид Сүрьеэд өртсөн олон нийтийн тогтвортой сүлжээ, хөдөлгөөнийг бий болгохын тулд хэрхэн нэгтгэх вэ? Үүний тулд үйл явц өрнөх ёстой гэж та санал болгож магадгүй. Тэр нь ч үнэн, тэгэхээр та дараах үйл явцыг ашиглаж болно: 1. олон нийтийг бэлтгэх, 2. Олон нийтийн удирдагчид, гишүүдийн чадавхийг бататгах, 3. Сүрьеэд өртсөн орон нутагт харилцах сүлжээг бий болгох, 4. нийгмийн бүлгүүдийг дайчлах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, 5. олон нийтийн оролцоо, түүний тусгал

Олон нийтийг дайчлах энэхүү таван чиглэл нь сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний явцад урд өмнө олж авсан туршлагад тулгуурласан юм. Олон нийтийг дайчлах үе шатанд санал болгож буй энэхүү таван бүрэлдэхүүн хэсэг нь тус тусдаа боловч, нэг нь нөгөөгөө нөхөж, нэгтгэдэг. Санал болгож буй үйл явц, алхам, үйл ажиллагааг доор харуулав:

### *3.2.1 Олон нийтийн бэлэн байдал*

Сүрьеэд өртсөн олон нийтийн гишүүд, олон нийтийг дайчлах, үйл ажиллагаанд татан оролцуулахын өмнө тэднийг зохих ёсоор бэлтгэх ёстой. Зорилтот бүлгүүдийг урдчилан бэлтгэхгүй бол цаг хугацаа, хүчин чармайлт, нөөц бололцоог дэмий үрэхэд хүргэж болзошгүй. Үр дүнтэй дайчилгаанд олон нийтийн бэлэн байдал маш чухал гэдэгтэй та санал нийлэх байх, тиймээс дараах хуудсан дээр дурдсан санал болгож буй алхам, үйл ажиллагаанд анхаарлаа хандуулаарай.



**Алхам 1:** Энд байгаа үйл ажиллагааны жишээнд зорилтот бүлгүүдийн **гишүүдтэй хийх үндсэн багийн анхны уулзалт**, олон нийтийн оролцооны зорилго, зорилгын **баг бүрдүүлэх хэд хэдэн удаагийн уулзалт**, харилцааг бий болгох тоглоомууд орно.

**Алхам 2:** Бэлтгэл үе шатанд цуглуулсан бүлгүүдийн талаарх мэдээлэл эсвэл нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн зорилтот бүлгийн иргэдэд эрүүл мэнд, сүрьеэтэй холбоотой асуудал, хэрэгцээний талаар мэдээлж, зөвлөлдөх.

Шаардлагатай эсвэл зохистой үед бүлгүүдийн талаар цуглуулсан мэдээллийг шинэчлэх ажлыг энэ алхмын явцад гүйцэтгэж болно. Эндэх боломжит олон үйл ажиллагаа нь зорилтот бүлгүүдэд чиг баримжаа олгох, удаа дараагийн уулзалт хийх, албан бус удирдагчидтай зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах, зорилтот бүлгүүдтэй мэдээлэл солилцох, зөвлөлдөхөд туслах тоглоомууд багтсан болно.

**Алхам 3:** Олон нийтийг дайчлах үйл ажиллагааны



**төлөвлөгөө боловсруулах.** Олон нийтийн оролцооны ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн нийгмийн бүлгүүдийн удирдагчид болон хамтрагчид, зорилтот бүлгүүдэд олон нийтийг дайчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахад нь тусална. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд зорилго, зорилт, стратеги, үйл ажиллагаа, үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, төсөв зэрэг багтана. Олон нийтийн удирдагчид гишүүдтэй хамт дараах үйл ажиллагааг явуулна:

- Зорилтот иргэдээс төлөвлөлтийн үндсэн багийг бүрдүүлэх
- Багийн гишүүдийн дунд үүрэг хариуцлагыг хуваалцах эсвэл хуваарилах
- Шаардлагатай бол цуглуулсан бүлгүүдийн талаарх мэдээллийн үр дүн эсвэл нөхцөл байдлын дүн шинжилгээг хянаж, шинэчлэх
- Тогтвортой харилцааг бий болгох, Сүрьеэд өртсөн олон нийтийг дэмжих, олон нийтийг дайчлах стратеги болон үйл ажиллагааг тодорхойлох
- Иргэдийг дайчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг тогтоох
- Төсөв боловсруулах
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг авах зорилгоор түүнийг түгээх, таниулах ажлыг тодорхойлж, хөгжүүлэх

**Алхам 4: Олон нийтийг дайчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг түгээх.** Үүнд Сүрьеэд өртсөн олон нийт, туншүүд болон бусад гол оролцогч талуудын өргөн хүрээнд гаргасан мөрийн хөтөлбөрөө хуваалцана. Тийнхүү өргөн хүрээтэй түгээх зорилго нь төлөвлөгөөний талаарх мэдээллийг хуваалцах, батлах талаар сурталчлах, хэрэгжүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлэх явдал юм. Түгээх үйл ажиллагаа нь олон нийтийн форум зохион байгуулах, танилцуулга хийх, баяр наадам зохиох зэргээр явагдахаас гадна олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллээ түгээнэ.



### 3.2.2 Сүрьеэ өртсөн олон нийтийн гишүүд болон удирдагчдын чадавхийг дээшлүүлж бататгах

Олон нийтийн оролцооны эдгээр хувь нэмрээ оруулагчдыг шаардлагатай мэдлэг, ур чадвар, зөв хандлагаар хангах нь маш чухал ач холбогдолтой. Дараах алхмууд нь сүрьеэгээр өвдөгсөд, сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүс, эмзэг бүлгийн хүн ам, олон нийтийн удирдагчид, гишүүдийн чадавхийг бэхжүүлэхэд чиглүүлэгч болж өгнө. Чадавхийг бататгахад ашиглаж болох арга хэрэгслүүд, жишээ нь: а. Буцаах тоглоом, р.126; б. Зүгээр л сонс тоглоом, р.129; болон в. Нөлөөлөхүйц ярих дасгал, х.132.

#### Алхам 1: Сүрьеэд өртсөн олон нийтийг чадавхжуулах

**ажилд оролцуулах.** Эхний ээлжинд олон нийтийн удирдагчид, гишүүдийг чадавхийг хөгжүүлэх үйл явцад оролцох оролцоог урамшуулах хэрэгтэй. Тэдэнд өөрсдийнх нь ажил болгож, үүрэг хариуцлагаа хуваалцаж, чадавхийг хөгжүүлэх тууштай байдлыг хангах ёстой.

Тэднийг татан оролцуулах зарим арга зам:

- Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах, ялангуяа сүрьеэд өртсөн иргэдийн уялдаа холбоотой, тууштай харилцааг бий болгох, олон нийтийн оролцооны өргөн хүрээнд чадавхийг хөгжүүлэх, утга учрыг хамтран тодорхойлох
- Тэдний хэрэгцээ, сонирхол, цаашид бататгах боломжтой чадавхийг үнэлэхэд өөрсдийг нь татан оролцуул. Олон нийтийн оролцоог дэмжих оролцооны үнэлгээг хийх талаар бодож үзээрэй.
- Чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд тэднийг татан оролцуулна.
- Чадавхийг хөгжүүлэх үйл явцын талаар тэдний санал хүсэлтийг тогтмол авч, оруулсан хувь нэмрийг нь үнэлж байх.



**Алхам 2: Олон нийтийн удирдагчид, гишүүд, байгууллагуудын дутагдал, тэргүүлэх чиглэл, хүлээлт, одоо байгаа ур чадвар, нөөц болоцоо, сүлжээг тодорхойлох чадавхийн үнэлгээг хийнэ.** Үүнийг хувь хүн (Олон нийтийн удирдагчид ба гишүүд) болон байгууллагын түвшинд эдгээр асуултыг үнэлгээний удирдамж болгон ашигладаг.


- Олон нийтийг дайчлах ажилд оролцох чадавхи хэр байна вэ?
- Олон нийтийг үр дүнтэй дайчлахад ямар чадавхи шаардлагатай вэ?
- Олон нийтийг дайчлах ажилд үр дүнтэй оролцоход саад болж буй чадавхийн сул талууд юу вэ?

Чадавхийн үнэлгээ хийхдээ та энэхүү номонд өгөгдсөн арга техникийг ашиглаж болно. Энэ алхамын хүлээгдэж буй үр дүн нь чадавхийн үнэлгээний үр дүнгийн талаарх товч буюу хураангуй тайлан юм.

**Алхам 3: Олон нийтийн удирдагчид, гишүүд, байгууллагуудын чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах.** Үнэлгээг хийж дууссаны дараа үндсэн дайчилгааны баг тодорхойлсон хүчин чадал, чадавхи, хэрэгцээ, шийдвэрлэх шаардлагатай дутагдал дээр үндэслэн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг бий болгоно. Чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг олон нийтийн удирдагч, гишүүдийн үүрэг, хариуцлага, байгууллагын чиг үүргийг бататгахад тохируулан боловсруулна. Чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр нь дараахь зүйлсээс бүрдэнэ:

- Чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны ерөнхий зорилго
- Сургалтын зорилго
- Хүчин чадлын дутагдлыг арилгах талаарх хөндөх сэдвүүд
- Хэрэгжүүлэх төлөвлөгөө – чадавхийг бэхжүүлэх, цаг хуваарилах, сургагч багш, чиглүүлэгч, гадаад нөөцийн хүмүүсийг тодорхойлох, шаардлагатай нөөц бололцоо, логистикийн арга хэрэгсэл
- Чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа бүрийн үнэлгээний аргачлал

Чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах хэрэгслийг 126-р хуудсанд оруулсан болно.



**Алхам 4: Чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.** Төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд дайчилгааны үндсэн баг дараахь ажлыг анхаарч үзэх шаардлагатай.


- Олон нийтийн удирдагчидтай хамтран чадавхийг хөгжүүлэх хөтөлбөртэй танилцаж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрч, хуваалцах, гишүүдийн дунд сурталчлах
- Шаардлагатай нөөцийг баталгаажуулах
- Үүнийг хэрэгжүүлэх түншүүдийг тодорхойлж, тэдэнтэй түншлэл тогтоох
- Бүрэн нэвтрүүлэхээс өмнө чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт сонгосон үйл ажиллагааг турших
- Туршилтын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх
- Анхны хэрэгжилтийн үр дүнд үндэслэн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ.

**Алхам 5: Чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрт хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх.** Чадавхийг хөгжүүлэх үйл явц эхлэхэд дайчлах үндсэн баг нь үнэлгээ хийх арга, шалгуур, үзүүлэлтийг тодорхойлоход Олон нийтийн удирдагчид болон гишүүдийг татан оролцуулна. Энэ нь тэд дараахь зүйлд оролцоно гэсэн үг юм:

- Цуглуулах мэдээллийн төрлүүд, мэдээлэл цуглуулах ажлыг хэн хийх талаар шийдвэр гаргах
- Олон нийтийн удирдагч, гишүүдийн олж авсан мэдлэг, үр чадвар, хандлагыг үнэлэх
- Чадавхийг бэхжүүлэх, суралцах үйл явцын агуулгыг үнэлэх, тэдгээр нь ажиллаж байгаа эсвэл өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох
- Хэрэгжиж буй чадавхийг хөгжүүлэх арга хэмжээний зардал, үр ашгийг үнэлэх.

**Бэрхшээлээс суралцах нь:  
ХДХВ-ийн Халдвартай Хүмүүсийн Олон нийтийн  
(APLHIV) түүх, Пакистан**

*“Пакистан бол сүрьеэгийн эсрэг сурталчилгаа бараг байдаггүй олон орны нэг нь юм. APLHIV-д бид урт удаан хугацааны туршид ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарлаа хандуулж ирсэн. Одоо бид сүрьеэтэй тэмцэх хөтөлбөр, чадавхийг хөгжүүлэхээр ажиллаж байна” гэж APLHIV-Пакистаны үндэсний зохицуулагч Асгар Сатти хэлэв.*



APLHIV-ийн гишүүд чадвараа хөгжүүлэхэд олон сорилттой тулгарч, үнэ цэнэтэй сургамж авсан. Асгарын өгүүлсэн тахлын туршлагын түүх бол онцгой байдлын үед төлөвлөх, яаралтай хариу арга хэмжээ авахад юу дутагдалтай байгааг харуулж өгснөөрөө сонирхолтой юм.

*“Ковид-19 тахал манай хаалгыг цохиход бид бүрэн цохорч, сандарч мэдвэн, юу хийх, яах ёстойгоо өгж мэдэхгүй байв. Бидэнд онцгой байдлын төлөвлөгөө гэж гаргасан юм байгаагүй” гэсэн билээ.*

Аливаа байгууллагын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт байгалийн гамшиг, тахал зэргийн бүх хүрээ, нөхцөл байдлыг хамран гаргах ёстой гэдгийг тэд тэрхүү түгшүүртэй мөчид л ойлгожээ.

“Пакистаны засгийн газар ХДХВ-ийн халдварын эсрэг үйлчилгээ үзүүлдэг Иргэний нийгмийн байгууллагуудыг (ИНБ) сайн мэддэг ч, сүрьеэгийн халдварт өртөгсдийн оролцооны талаар төдийлөн сайн мэддэггүй явж ирсэн. Одоогийн байдлаар, улсын болон орон нутгийн түвшинд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад ард иргэд ямар үүрэг гүйцэтгэж болох талаар төр засгийнхан хараахан бүрэн ойлголтгүй байна. Тэр нь ч манай Олон нийтийн удирдагчид, түншүүдийн хувьд томоохон сорилт болж байна.” Энэ сорилтоос сургамж авсан зүйл бол Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон засгийн газрын бусад байгууллагуудтай хамтран ажиллахдаа ашиглах нөлөөллийн төлөвлөгөө гаргах шаардлагатай тухайд юм.

*“Сүрьеэгийн эсрэг үр дүнтэй, утга учиртай, ашигтай идэвхтэй үйл ажиллагаа Пакистанд нэн чухал байна. Манай засгийн газрын түншүүд сүрьеэд өртсөн олон нийтийн хэрэгцээ, ач холбогдлын талаар тогтмол мэдлэг мэдээлэлтэй байх нь тавигдаж буй зорилго юм. Энэ бол сүрьеэд өртсөн олон нийтийн сурталчилгааны кампанит ажлын үндсэн чиглэл юм” гэж Асгар өгүүсэн билээ.*

*“Анхан шатны нэгжээс авсан сургамж нь биднийг аливаад үндэслэлтэй хандахад тусалдаг, сорилт болгоны сургамж нь өөрсдийгөө чадваржуулах, сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах чадавхийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Бид бат итгэл найдвартай, тууштай урддын адил хэвээр байна.”*

### 3.2.3 Сүлжээ холбоо үүсгэх

Энэхүү номын эхний хэсэгт бид олон нийтийн гишүүд сүлжээ холбоо бий болгоход оролцох хүсэл эрмэлзэлтэй байдаг, учир нь энэ нь **жижиг байгууллагуудын чадавхийг өргөжүүлэх, нөөц бололцоог дайчлах ажлыг хурдасгах, байгууллага хоорондын харилцан уялдаатай байх** соёлыг хөгжүүлэх, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхийн тулд оршин тогтнох чадвартай институци болон зохион байгуулалтын дэд бүтцийг бий болгоход хувь нэмэр оруулна гэдгийг дурдсан. 4-р хэсэгт бид дараах хөнгөвчлөх хэрэгслүүдийг оруулсан: а. Сүлжээ холбооны тухай ойлголт, х.134; б. Олон нийтийн удирдагчид, гишүүдэд зориулсан стратегийн сэтгэлгээ, х.136; в. Санхүүгийн мэдлэг, х.138; болон д. Үзэл баримтлалыг бэлтгэх, х.143.

2023-2025 он хүртэл Глобаль сангийн 7-р тэтгэлэгт (GC7) хамрагдсан тухай баримтжуулахдаа олон нийтээс өгсөн зөвлөмжийн нэг нь нэгдсэн зохион байгуулалтанд орж, бэхжүүлэх явдал байв.<sup>45</sup> Үүнд:

- Гишүүнчлэлээр дамжуулан сүрьеэгээр өвдөөд эдгэрсэн хүмүүсийн бүлгийг өргөжүүлэх
- Нэгдсэн зохион байгуулалтанд орох, эрхээ өмгөөлж, хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх замаар холбоогоо бэхжүүлэх
- Итгэлцлийг бэхжүүлэх дасгалууд болон манлайллын ур чадварыг хөгжүүлэх замаар хамт олныг төлөвшүүлэх
- Бусад оролцогч талуудтай (үндсэн хүлээн авагчид, ҮЗЗ, үндэсний механизм) харилцаа холбоог бэхжүүлэх
- Уулзалт, харилцаа холбооны ажил гэх мэт ложистикийг дайчлахад нэмүү дэмжлэг үзүүлэх
- Иргэний нийгмийн байгууллагуудад санхүүжилтийг дамжуулах илүү хүчирхэг платформ боловсруулах



Дарси Ашман болон түүний нөхөд Олон Улсын Хөгжлийн Хөтөлбөрүүдэд Иргэний Нийгмийн Сүлжээг Дэмжих тухай гарын авлагадаа ийнхүү дурдсан байдаг:

*Иргэний нийгмийн бүлгүүд, байгууллагууд тогтвортой хөгжил, ардчилсан засаглалын зорилгод хүрэхийн тулд сүлжээг бий болгож, эдгээр зорилгод дангаараа хүрч чадахгүйгээ ухамсарладаг. Сүлжээ холбоо нь бодлогыг сурталчлах, засаглалыг сайжруулах иргэдийн дуу хоолойг хүргэх хүчийг нэмдэг. Сүлжээ нь мэдээлэл, нөөц бололцоог хуваалцах эсвэл зохион байгуулалттай хүргэх системийг хөгжүүлэх зорилгоор үйлчилгээ үзүүлэгчдийг холбож болно. Иргэний нийгмийн сүлжээ холбоо нь хөтөлбөрийнхөө цар хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэхийг эрмэлздэг олон улсын хөгжлийн агентлагуудын сонголтын түнш болсон.*<sup>46</sup>

Энэхүү номонд сүрьеэд өртсөн олон нийтийн сүлжээ холбоо бий болгох санаа нь иргэний “нийгмийн хөгжил эсвэл ардчилсан засаглалын нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сайн дураараа нэгддэг иргэний нийгмийн бүлгүүд, байгууллага, заримдаа хувь хүмүүс гэж тодорхойлж болно” гэсэн үзэл бодолтой нийцэж байна. Эдгээр зорилгод нөөц бололцоо солилцох, нийгмийн нийтлэг зорилтуудыг шийдвэрлэх, эсвэл нийгэм, нийгмийн бүлэг гэдгээ илэрхийлэх зэрэг байж болно.” Үүнд албан ёсны байгууллага эсвэл албан ёсны бус нийгмийн харилцаа байж болно.

Сүрьеэд өртсөн олон нийтийн үндэсний болон бүс нутгийн хүчирхэг сүлжээтэй бол тэд төрийн болон төрийн бус байгууллага, байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж, нийгэмлэг болон олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэхэд тогтвортой дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.


Сүрьеэд өртсөн олон нийтийн холбоог ашиглан тогтмол нэгдсэн хөдөлгөөнийг бий болгохдоо бид дараах хэдэн асуултыг анхаарч үзэх хэрэгтэй:

- Бидэнд хэний хамтын ажиллагаа хэрэгтэй вэ?
- Бидэнд хэний зөвшилцөл, зөвшөөрөл хэрэгтэй вэ?
- Энэ Олон нийтийн оролцооны зорилгод хүрэхэд хэний эсэргүүцэл болох вэ?

Сүлжээ холбоо бий болгох гол элементүүд юу вэ? Судалгаа, туршлага дээр үндэслэн дараах үндсэн үйл ажиллагааны алхмууд нь сүлжээ үүсгэхэд хамааралтай бөгөөд хэрэгтэй:

- **Гол асуудлаа тодорхойлох, үйл явдал дээр төвлөрсөн сүлжээ холбоог бий болгох.** Одоо байгаа оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, эсвэл шинэ байгууллага, холбоо бий болгох үр дүнтэй арга бол тодорхой, утга учиртай, биелэх боломжтой богино болон дунд хугацааны эхний нэг эсвэл хоёр зорилтыг тодорхойлох явдал юм. Эдгээр “тодорхойлох” асуудал эсвэл үйл явдлууд нь эхлээд оролцоо, дэмжлэгийг бий болгоход үйлчилдэг бөгөөд эцэст нь сүлжээний онцлогийг бэхжүүлэхэд тустай. Бид энэхүү эхний алхамыг асуудлыг тодорхойлох, зорилго тавих гэж нэрлэдэг.”<sup>48</sup>





- **Түншлэлийг бий болгох:** Нийтлэг асуудал, зорилгыг тодорхойлсны дараа олон нийтийн оролцооны багийн дараагийн алхам бол тухайн бүс нутагт байгаа түншүүд эсвэл эвслийг судлах явдал юм. Сүрьеэгээр өвдсөн иргэдийн сүлжээг бий болгоход оролцох шаардлагатай юу, тэдний одоогийн хүчин чармайлт таны зорилго, санаачилгатай хэрхэн уялдаж байна вэ? Энд боломжит түншүүд/эвслийн үнэлгээ, зураглал хийх нь чухал юм.
- Сүлжээнд хамтын манлайлал, төлөөллийн засаглал, удирдлагыг зохицуулах **үр дүнтэй тогтолцоог бий болгох.** Энэ алхам нь үндсэндээ сүлжээн дэх сүрьеэд өртсөн олон нийтийн оролцооны дүрмийг тогтоодог.
- Сүрьеэд өртсөн олон нийт, орон нутгийн удирдагчид болон гишүүдийн **чадавхийг бэхжүүлэх.** Удирдагчдын хувьд зөвшилцөлд хүрэх, яриа хэлэлцээг хөнгөвчлөх, шийдвэр гаргахад ардчилсан журмуудыг баримтлах зэрэг ардчилсан практикт ур чадвараа дээшлүүлэх хэрэгтэй. Сүлжээний гишүүд харилцаа холбоо, зохицуулалт, шийдвэр гаргахад оролцох


чадвараа хөгжүүлэх ёстой. Энэ бол олон нийтийн оролцооны төлөвлөгөөний нэг хэсэг юм.

- Сүрьеэд өртсөн олон нийтийн дунд хүчирхэг сүлжээг бий болгохын тулд ил тод, үр дүнтэй харилцааны тогтолцоог бий болгох. Энэ нь сүлжээний гишүүдийн хооронд үр ашигтай, цаг тухайд нь мэдээлэл солилцох боломжийг олгодог. Үр дүнтэй харилцаа холбоо нь тодорхой суваг, протоколтой байдгаараа онцлог бөгөөд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад шаардлагатай мэдээллийг хялбархан олж авах боломжтой. Харилцаа холбооны төлөвлөгөө нь сүлжээнд тусгайлан тохируулсан харилцааны стратегийг агуулсан байх шаардлагатай.

### Олон нийтийн оролцооны үйл ажиллагаанд гол тоглолтыг хэрхэн татах вэ?

*“Хмерийн ХДХВ-ДОХ-ын эсрэг ТББ-ын холбоонд хандах бидний хандлага олон нийтийг дайчлахаас эхэлдэг. Бид оролцоход бэлэн байна. Ингэснээр бид үр дүнтэй, утга учиртай олон нийтийн оролцоог бий болгож чадна гэдэгт итгэж байна”* гэж гүйцэтгэх захирал Чоуб Чамреун, Камбожийн Улсыг зохицуулах механизмын одоогийн дэд дарга хэлэв. ХАНА бол Камбожийн олон нийтийн байгууллагуудтай хамтран ХДХВ-ДОХ, сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэх, олон нийтийн түвшинд дэмжих үйлчилгээ зэрэг өвчний хариу арга хэмжээний талаар хамтран ажилладаг үндэсний төрийн бус байгууллага юм.

KHANA-ийн Бодлого, түншлэл, сүлжээний ахлах зохицуулагч Форнг Чанторн болон Чамреун хэлэхдээ, *“Бид олон нийтийн оролцоонд эерэг болон бэрхшээл олныг туулсан.*




*Бид сүрьеэд өртсөн олон нийтдээ хамтран ажиллах, ялангуяа тэднийг олон нийтийн оролцооны үйл явцад татан оролцуулах тал дээр үнэ цэнэтэй ойлголт олныг олж авсан. Бусадтай хуваалцах нь зүйтэй гэж үзсэн ойлголт, сургамжаасаа зарим жишээг энд оруулах нь зүйтэй.”*

**1. Итгэл найдварын хэлхээг бий болгох:** *“ХАНА-гийн олон нийтийг дайчлах, сүлжээг бий болгох гол захиас бол “Та сүрьеэ өвчнөөс ангид байх ёстой бөгөөд та зөвхөн үйлчлүүлэгч төдийгүй гэр бүлийнхээ бат бэх тулгуур болох олон нийтийн үйл ажиллагаанд оролцох ёстой.” Энэ бол ХАНА-гийн олон нийтийг дайчлах үйл ажиллагаа, сүлжээг бий болгох гол санаа юм. Сүрьеэгийн талаар мэдлэг олгох үйл ажиллагаатай зэрэгцэн итгэл найдварын хэлхээг бий болгоход анхаарлаа төвлөрүүлэхийн тулд өгөх санаагаа тохируулах нь эерэг хариуг авчирдаг болохыг тэд олж мэдэв. Сүрьеэгээр өвдсөн хүмүүст зориулсан хүчирхэг дэмжлэгийн тогтолцоог бий болгох давуу талуудын талаарх мэдээлэл авсны дараа тэдний зарим нь үе тэнгийнхнийгээ дэмжих бүлгийг байгуулах ажлыг идэвхтэй эхлүүлсэн.*

**2. Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахдаа холбоо хамаарал, уялдаа холбоотой байхын ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.** *Сүрьеэгийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, түүнийг зогсоход хувь хүмүүс хэрхэн хувь нэмрээ оруулж болох нь сүлжээн дэх байгууллага болон хувь хүмүүсийн хоорондын нийгмийн капиталыг бий болгоход тустай. Сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг харагдуулах нь мэдлэгийг дээшлүүлэх санаачилгатай салшгүй хэсэг юм. Сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг харагдахуйц болгох нь эдгээр мэдлэг олгох санаачилгын нэг хэсэг юм.”*

**3. Дэмжлэг байгааг мэдэх нь Олон нийтийн идэвхтэй оролцоог дэмждэг:** *“Тус бүс дэх манай сүлжээний гишүүдэд Олон нийтийн байгууллагуудаа*

*үр дүнтэй удирдахад шаардагдах ур чадвар одоогоор дутмаг байна. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагааны чиглэл боловсруулах, тэдний үүрэг, хариуцлагыг тодорхой болгоход бид дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаа нь тэдний хувьд чухал юм.”*



### 3.2.4 Олон нийтийг дайчлах үйл ажиллагаа

Дайчилгааны арга хэмжээ нь сүрьеэд өртсөн олон нийт сүлжээ дэх харилцан уялдаатай, тогтвортой, нэгдсэн хөдөлгөөнийг бий болгох, чадавхийг бататгах зорилготой юм. Иймд сүрьеэд өртсөн олон нийт, түншүүд болон бусад оролцогч талуудыг хамарсан дайчлах үйл ажиллагаа нь дараах чиглэлд төвлөрнө:

- Сүрьеэд өртсөн олон нийтийн **оролцоо, дуу хоолойг институт болгох** 1. Бодлого, шийдвэр гаргах форумууд болон 2. Сүрьеэгийн хариу арга хэмжээний засаглал ба удирдлага. Үүнд:
  - Сүрьеэгийн асуудалд нөлөөлөх бодлогын өөрчлөлтийн талаарх орон нутгийн болон үндэсний форумд оролцох
  - Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах хяналтын байгууллагад гишүүнээр элсэх
  - Хүний эрхийн үнэлгээний картын хэрэгжилт
  - Үндэсний зохицуулах зөвлөл (ҮЗЗ) болон засгийн газрын бодлого боловсруулахад нөлөөлж, бодлогын өөрчлөлтийг авчрах бусад олон талт байгууллагуудад гишүүнээр элсэх

### Улс орны жишээ<sup>49</sup>:

“Камбож улсад сүрьеэд өртсөн олон нийтийн оролцоо, эрх, жендэрийн (CRG) асуудлыг Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөр болон Үндэсний Зохицуулах зөвлөл (ҮҮЗ) тусгах талаар үр дүнтэй оролцож, сурталчилж байна.”

Сүрьеэд өртсөн олон нийтийн чадавхийг дүүрэг болон Үндэсний Сүрьеэгийн Хөтөлбөрт нийгэмлэг, эрх, жендэрийн (CRG) арга барилыг идэвхтэй сурталчлах, Балбын Үндэсний Сүрьеэгийн Хөтөлбөрийн хүрээнд нийгэмлэг, эрх, жендэрийн холбоотой үйл ажиллагааг дэмжихэд дотоодын нөөц бололцоог хамруулах талаар сурталчлах ажлыг хийж байна.

- Сүрьеэд өртсөн ард иргэдийг үндэсний стратеги, өртөг зардалтай төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд **илүү их нөлөө үзүүлэх боломжийг олгох**. Эдгээр төлөвлөгөөнд хүний эрх, жендэр, хариу арга хэмжээ, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой бодит байдал, хэрэгцээ шаардлагыг зохих ёсоор авч үзэж, шийдвэрлэх ажлыг баталгаажуулдаг. Үүнд:
  - Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Сүрьеэгийн Техникийн ажлын хэсэгт гишүүнээр элсэх
  - Сүрьеэтэй Тэмцэх Хөтөлбөрийн хамтарсан үнэлгээнд оролцох
  - Глобаль сангийн саналыг боловсруулах, буцалтгүй тусламж олгох үйл явцад оролцох
  - Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний хүрээнд олон нийтэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хамруулах талаар таниулах сурталчилгаа явуулах
  - Сүрьеэгийн үндэсний стратеги төлөвлөгөө, хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, Сүрьеэгийн хөтөлбөрийн төсвийг боловсруулахад оруулсан хувь нэмэр, үүнд төр засгийн гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагуудын төсвийн хэлэлцүүлгийн явцад оролцох

### Улс орны жишээ<sup>50</sup>:

- *Вьетнам дахь сүрьеэд өртсөн, гадуурхагдсан олон нийтийг (эмэгтэйчүүд, хуучин хоригдлууд, Төв өндөрлөг*

дэх үндэстний цөөнхүүд) сүрьеэгийн эсрэг орон нутгийн болон Үндэсний Хөтөлбөрүүдэд олон нийт, эрх, жендэрийг нэгтгэх талаар чадварлаг сурталчлах боломжийг олгох.

“Сүрьеэтэй Тэмцэх Олон Нийтийн Дэмжлэг Үзүүлэх Бүлгүүд” нь олон нийт, эрх, жендэртэй холбоотой асуудлуудыг сурталчлах, тэр дундаа олон нийтээс боловсруулсан Сүрьеэтэй Тэмцэх Олон Нийтийг Дайчлах Стратегийг Пакистаны Үндэсний Сүрьеэтэй Тэмцэх Хөтөлбөрт нэгтгэхийг дэмжих эрхтэй.”

- Сүрьеэд өртсөн олон нийтийг **чадавхжуулахад**: 1. Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрын хамрах хүрээ, чанар, амлалтад хяналт тавих, мөн 2. хийсэн мэдээллийг сурталчлах, хөтөлбөрийн үйл ажиллагаанд ашиглах. Үүнд:
  - Хөтөлбөр, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ болон үнэлгээ хийх ажилд оролцох
  - Иргэдийн оролцоотой хяналтыг бий болгох болон хэрэгжүүлэх. Олон нийт удирдсан хяналтыг болон баримт бичгийн тайлангаас олж авсан мэдээллийг нөлөөллийн хүчин чармайлт болон бодлогын яриа хэлэлцээнд ашигладаг.
  - Сүрьеэгээр өвдсөн олон нийтийг эрх, хүйсийн тэгш бус байдалтай холбоотой асуудлаар дайчлах зорилгоор харуулын үүргийг гүйцэтгэнэ.

#### Улс орны жишээ<sup>51</sup>:

“Индонезийн сүрьеэд өртсөн ард иргэд олон нийтийн үйл ажиллагааны судалгааны үр дүнг ашиглан эмэнд тэсвэртэй сүрьеэтэй хүмүүсийн нийгмийн хамгааллын механизмд дуу хоолойгоо хүргэж чадна. Түүнчлэн тэд олон нийт, эрх, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар Сүрьеэгийн үндэсний хөтөлбөрт Олон нийт, эрх, жендэрийн хэтийн төлөвийг тусгах зорилготой.”

Индонезийн сүрьеэд өртсөн ард иргэд олон нийтийн үйл ажиллагааны судалгааны үр дүнг ашиглан эмэнд тэсвэртэй сүрьеэтэй хүмүүсийн нийгмийн хамгааллын механизмд дуу хоолойгоо хүргэж чадна. Түүнчлэн тэд олон нийт, эрх, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар Сүрьеэгийн үндэсний хөтөлбөрт Олон нийт, эрх, жендэрийн хэтийн төлөвийг тусгах зорилготой.

(Олон нийтийг дайчлах үйл ажиллагааг сурталчлах арга хэрэгслийг энэхүү номын 4-р хэсэгт оруулсан болно. Үүнд: а. Өгүүлэх өнгө тоглоом, х.146; б. Өгүүлэх шоо тоглоом, х.149; в. Тойргийн иргэдийн зөвлөлдөх уулзалтад бэлтгэх асуудал. х.151; г. Ярилцах цэгүүдийг хэрхэн боловсруулж, танилцуулах вэ, х.153; д.Нөлөөллийн төлөвлөлтийн үлгэрчилсэн гарын авлага, х.155.)

### Ялалтад хүрэх аягуу стратеги: Вьетнамаас авсан сургалж

*“Иргэний нийгмийн хөдөлгөөний тухай ойлголт манай улсад шинэлэг хэвээр, ерөнхийдөө олон нийтийн оролцооны соёл бидэнд дутмаг байна. Одоогоор үүнд хууль эрх зүйн орчин байхгүй байна”* гэж тус төвийн Нийгмийн дайчилгааны менежер Вї Ngõc Ноа тайлбарлав. Олон

нийтийн Хөгжлийн Санаачилгыг Дэмжих Сан (SCDI) нь эмзэг бүлгийн болон гадуурхагдсан хүн амын амьдралын чанар, олон нийтийн оролцоог сайжруулах, байгаль орчинд хор хөнөөл учруулж болзошгүй үйлдлүүдийг бууруулах зорилготой Вьетнамын ашгийн бус байгууллага юм.

*“Сүрьеэтэй хүмүүсийн ихэнх нь зөвхөн эмчилгээндээ санаа тавьдаг нь үнэн, болж л өгвөл аль болох хурдан хэвийн амьдралдаа эргэж орохыг тэд хүсдэг. Тэднийг ухуулга сурталчилгаа, дайчлах үйл ажиллагаанд нэгдэж оруулцахад тун амаргүй. Бусдын эрх ашгийг хамгаалах тухай ойлголт нь тус улсын олон нийт, Олон нийтийн гишүүдэд төдийлөн танил бус, ер бусын мэт санагддаг”* гэж тэрбээр өгүүлэв.

*“Бид сүрьеэтэй хүмүүс болон тэдний ар гэрийнхэнтэй шууд холбоо барьж хөдөлгөөн, сурталчилгааны кампанит ажилд татан оролцуулах ямар ч боломжгүй. Үүний оронд бид харин Олон нийтэд түшиглэсэн байгууллагууд (CBOs) эсвэл орон нутгийн албан бус удирдагчидтай хамтран ажилладаг юм. Бид тэдний сүрьеэд өртсөн олон нийттэй харилцах чадварыг сайжруулдаг.”* Энэхүү стратегиар дамжуулан тус байгууллага олон нийтийн гишүүдийн дунд сурталчилгааны ажлыг үр дүнтэй явуулж байна.

*“Бид Зөөлөн стратегийг хэрэгжүүлэх замаар олон нийтийн оролцооны замналаа удирдан чиглүүлдэг, энэ нь ч бидэнд*



*ашигтай нь батлагдсан. Энэ л бидний арга барил ялимгүй боловч олон ялалтыг бий болгоход хүргэсэн юм.” Олон Нийтийн Хөгжлийн Санаачлагыг Дэмжих Төв (SCDI) засгийн газартай харилцахдаа энэхүү аядуу стратегийг адилхан ашигладаг билээ. “Бид байгууллагаа, олон нийтийг засгийн газар, бодлого боловсруулагчидтай хамтран ажилладаг түнш хэмээн үзэж тууштай байр суурь илэрхийлдэг. Заримдаа бүтээлч шүүмжлэл гаргадаг ч бидний санал шүүмжлэл хэтэрхий хазайсан, хатуу ширүүн байх нь тун ховор.”*

Аядуу стратегийг хэрэгжүүлэхэд амжилттай болох нь ийнхүү батлагдсан, одоогоор Олон нийтийн хөгжлийн санаачлагыг дэмжих төв (SCDI) энэ аргыг олон нийтийн оролцоонд ашиглахаар тууштай ажиллаж байна. “Засгийн газар болон бодлого боловсруулагчдад шууд тайлбар өгөхийн тулд тэдэнтэй итгэлцэл, түншлэлийн уур амьсгалыг бий болгоно гэхдээ урт удаан хугацаа шаардагддаг. Бид олон нийтийн сайн сайхны төлөө эдгээр харилцааг тогтвортой байлгахын төлөө бүхнээ зориулдаг.”

### 3.2.5 Олон нийтийн дайчилгааны оролцоонд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх

Олон нийтийн оролцооны төлөвлөгөөний хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоо бий. Энэ нь олон нийтийг дайчлах үе шат дахь оролцооны ахиц дэвшлийг хянах, үнэлэх ерөнхий зорилго, стратеги, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоодог.

Сүрьеэд өртсөн олон нийтийг өөрсдийн сүлжээн дэх тогтвортой нэгдсэн хөдөлгөөнийг бий болгохын тулд олон нийтийг дайчлах ажилд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхдээ дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг авч үзэж болно:


- 1. Бодлого, шийдвэр гаргах форумд оролцох, түүнчлэн б.сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах засаглал, удирдлагад оролцож буй ахиц дэвшлийг хянахын тулд



**олон нийтээр удирдуулсан хяналтын үйл явцыг ашиглах.**


- Дайчилгааны үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог үнэлэхийн тулд **оролцооны үнэлгээний арга, хэрэгслийг ашиглана** уу. Ялангуяа бид дараах алхмуудыг хийхийг зөвлөж байна:
  - Үнэлгээний тодорхой зорилтууд болон олон нийтийг дайчлах үйл ажиллагаанд оролцох шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох
  - Шалгуур үзүүлэлтүүдийн мэдээлэл цуглуулах аргыг нэвтрүүлэх
  - Өгөгдлийн шинжилгээ болон үнэлгээний үр дүнг танилцуулах аргуудыг тодорхойлох
  - Үнэлгээний үйл явц, үйл ажиллагааны бүх үе шатанд олон нийтийг оролцуулах
  - Үнэлгээний үйл явц, үр дүнгийн талаар эргэцүүлэн бодох хичээл явуулах

(Та энэхүү номын 4-р хэсэг, хуудас 158-д заасан оролцооны үнэлгээний хэрэгслүүдийг ашиглана уу.)



### Сүрьеэ ба хүний эрхийн үнэлгээний картын талаарх эргэцүүлэл: ГБХТГ-ын туршлага

“НҮБ-ын Дээд түвшний уулзалтын үеэр гарсан ахиц дэвшлийг үнэлэхийн тулд Сүрьеэгийн эсрэг Түншлэл Индонези (STPI) нь APCASO-аас боловсруулсан Сүрьеэ ба Хүний Эрхийн Үнэлгээний Картыг ашиглахаар сонгосон. Тэр хурлаар сүрьеэгийн эсрэг эрхэд суурилсан, жендэрт суурилсан хариу арга хэмжээ авах тухай тунхаглал гарсан. Эрх дээр суурилсан хариу арга хэмжээний жинхэнэ утгыг эргэцүүлэн бодох нь ашигтай” гэж STPI-ийн Түншлэл, хөгжлийн менежер Теа Хутанамон хэлэв.



Сангийн хувьд STPI нь Индонезид сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийг урагшлуулахын тулд засгийн газар, хувийн хэвшил, олон нийттэй хамтран ажилладаг. Дүүрэг, тосгоны түвшинд засаглал, бодлогын өөрчлөлт, ялангуяа сүрьеэгийн төсөвт тусгах болон мултимедиа кампанит ажил явуулдаг. Ийм замаар сүрьеэгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зэрэг нь энэ сангийн анхаарах гол чиглэлийн нэг юм.

Үнэлгээний хэрэгсэл болох онооны картын нэг гол зорилго нь сүрьеэгийн эсрэг үндэсний эрхэд суурилсан иргэний нийгэм болон Сүрьеэд өртсөн олон нийтийн үзэл бодлыг цуглуулах явдал юм. Дараа нь цуглуулсан нотлох баримтыг сүрьеэгийн үйлчилгээ, хөтөлбөр, бодлогод суурилсан хандлагыг хэрэгжүүлэхэд хэрэглэдэг. Тэрчлэн нөлөөлөл, үйл ажиллагааг дэмжих, Сүрьеэд өртсөн иргэд, засгийн газар болон бусад гол оролцогч талуудын хоорондын яриа хэлэлцээг дэмжихэд ашигладаг.

Хутанамон 2022 онд тэд Ява арлын сүрьеэтэй тэмцэх байгууллагуудын гишүүдтэй нүүр тулж, онооны хуудсыг хийсэн боловч, судалгаанд оролцогчдын тоо хязгаарлагдмал байсан гэв. Үнэлгээний хуудасын баримт бичгийг өөрийн орны хэл рүү орчуулж, ярилцлагын явцад ашигласан байна.

• *Үнэлгээний хуудасын үр дүн гарахад оноо нэлээд доогуур байгаа нь анзаарагдсан. Асуулгын үйл явц, төрлийг эргэцүүлэхэд онооны хуудас нь нийгэмд төвлөрсөн, нийгэм рүү чиглэсэн байсан тул үүнийг ч урьдчилан таамаглаж байсан” хэмээн Хутанамон тайлбарлав.*

STPI нь үнэлгээний хуудасны тайланг Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөртэй хуваалцахыг хүссэн боловч, Засгийн Газар үр дүнг эерэгээр хүлээж авахгүй байх вий гэж санаа зовж байв. 2023 оны эхээр тэд ижил асуултыг ашиглан APCASO-оос Засгийн Газартай хамтран үнэлгээний хуудасныг хэрэгжүүлэх боломжийн талаар зөвлөгөө авахыг хүссэн. Хэлэлцүүлгийн дараа тэд үнэлгээний хуудаснын маягыг сонгогдсон төрийн хариуцагчдад цахим шуудангаар илгээв.

• *Гэхдээ бид Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөр болон нэг аймгаас маягт бөглөхийг хүссэн цөөн хэдэн хариулт авсан. Дөрвөөс таван дүүргийн сүрьеэгээр өвчлөгсдийн байгууллагуудад маягт тараахад Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөр дэмжлэг үзүүлсэн. Цөөн түүврийн улмаас бид үр дүнг тайланд оруулаагүй, энэ нь ч хэтийн төлөвийг бүхэлд нь тусгахгүй гэж үзсэн” хэмээн Хутанамон цааш тайлбарлав.*

Сүрьеэд өртсөн хүмүүс болон засгийн газрын судалгаанд хамрагдагсдаас авсан Үнэлгээний

хуудасын үр дүнг эргэцүүлж үзэхэд, СТПИ-ийнхэн асуултанд хэрхэн оноо өгсөнд нь ялгаатай байгааг олж харав. Тухайлбал, сүрьеэгийн талаарх мэдээлэл иргэдэд хүртээмжтэй байгаа эсэх, мэдээлэл хэр хангагдсан бэ гэсэн асуултад төрөөс долоо, найм гэсэн маш өндөр оноо өгсөн бол, сүрьеэгээр өвдсөн иргэд таваас доош оноо өгсөн байв.

Хутанамонын хэлснээр, Үнэлгээний хуудасын туршлагаас хоёр чухал зүйлийг сурсан. Нэг нь засгийн газрын олон хүмүүс болон сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн дунд сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авах хүний эрхийн талаарх мэдлэгийн зөрүү байгааг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Тэдэнд иргэний нийгмээс ялгаатай нь сүрьеэгийн хөтөлбөр, бодлого боловсруулахад эрхэд суурилсан хандлагын талаар сургалт дутмаг байв. Өөр нэг сургамж бол ИНБ болон Олон нийтийн хийж байгаа зүйлийг Засгийн Газар эзэмшиж байгаатай холбоотой. Тэд сүрьеэгийн эсрэг Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг хэсэг хэмээн өөрсдийн ажлыг хүлээн зөвшөөрдөг тул маш өндөр оноо өгсөн. Нөгөөтэйгүүр, ард иргэд сүрьеэгийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх нь Засгийн Газрын үүрэг гэж үзсэн. Тиймээс тэдний хувьд олон нийтэд мэдээлэл авах боломж хязгаарлагдмал тул тухайн асуултын бага оноотой байна.

• “Том дүр зургийг харвал, бид сүрьеэгийн эсрэг  
• хариу арга хэмжээ авахдаа харилцан  
• хамааралтай орон зайг нэмэгдүүлэх хэрэгтэй.  
• Нэг ёсондоо төр, иргэний нийгэм, олон нийт  
• хоорондоо ихээхэн хамааралтай байдаг. Бид  
• Глобал санд улс орны санал болон бусад олон  
• ажлыг хамтран бэлтгэсэн. Гэхдээ бид  
• сүрьеэгийн эсрэг тэмцэхэд эрхэд суурилсан  
• хандлагыг дэмжиж байгаа, бид үүний төлөө  
• зогсож байна” хэмээн Хутанамон дүгнэв.

### 3.3 Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх (CSS) үе шат

Энэ үе шат нь сүрьеэд олон нийтийг өөрсдийн сүлжээн дэх тогтвортой нэгдсэн хөдөлгөөнийг бий болгоход бэлэн байна гэсэн санаан дээр суурилдаг. Олон нийтийг дайчлах үйл ажиллагаа эхэлсэн, цаашид үргэлжилж байна гэж үздэг. Энэ нь ч олон нийтийн оролцооны үйл явцыг эрчимжүүлж, өргөжүүлнэ гэсэн үг юм. Хэлэлцүүлгээр бид түүний утга учир, зорилго, хүрээ, бүрэлдэхүүн хэсэг, Сүрьеэд өртсөн олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх, CSS дахь олон нийтийн оролцоо зэрэг асуудлыг авч үзэх болно.

#### 3.3.1 Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх ажиллагааны тодорхойлолт ба зорилго

Эхлээд олон нийтийн тогтолцооны тухай ойлголтыг тодорхой болгоё. Глобаль сан олон нийтийн тогтолцоог “Олон нийт болон түүнд түшиглэсэн байгууллага, бүлгүүд харилцан үйлчилж, зохицуулж, тэдний нийгэмд нөлөөлж буй бэрхшээл, хэрэгцээ шаардлагад хариу арга хэмжээ авч, хамтран ажилладаг олон нийтээр удирдуулсан бүтэц, механизмууд юм” гэж тодорхойлсон. Олон нийтийн систем нь жижиг эсвэл албан бус, бусад нь илүү өргөн хүрээтэй байдаг-тэдгээр нь хэд хэдэн байгууллагын хооронд сүлжээ үүсч, янз бүрийн дэд системүүдийг хамардаг.”<sup>52</sup>

Нөгөө талаар олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх нь дараахь байдлаар тодорхойлогддог.

• “Мэдээлэлтэй, чадварлаг, зохион байгуулалттай олон нийтэд түшиглэсэн байгууллага, бүлэг, бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн арга барил юм. Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх нь нийгмийн өргөн хүрээг хамарч, олон нийтийн түвшинд эрүүл мэнд болон бусад оролцоог урт хугацаанд тогтвортой байлгахад бусад оролцогчтой адил тэгш түншийн хувиар хувь нэмрээ оруулах боломжийг олгодог бөгөөд энэ нь эдгээр хувь нэмрийг үр дүнтэй дэмжиж, хариу үйлдэл үзүүлэх орчинг бүрдүүлэх явдал юм. Үүнд эдгээр хувь нэмэр үр дүнтэй байх, таатай хариу үйлдэл үзүүлэх орчин бий болно.”<sup>53</sup>

Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх зорилго нь “үйлчилгээг төлөвлөх, хүргэх, хянах, үнэлэхэд сүрьеэд өртсөн хүмүүс, олон нийт болон олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын үүргийг хөгжүүлэх замаар эрүүл мэндийн сайжруулсан үр дүнд хүрэх мөн ХДХВ, сүрьеэ, хумхаа болон бусад өвчнөөр өвдсөн хүмүүсийг урьдчилан сэргийлэх, эмчлэх, халамжлах, дэмжихтэй холбоотой үйл ажиллагаанд оршино.”<sup>54</sup>

Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахын тулд олон нийтийн чадавхийг хөгжүүлэх, тогтолцоог бэхжүүлэх арга барилыг институцижуулах мөн сүрьеэд өртсөн иргэдийн эрүүл мэнд, болон хөгжлийн талаарх хууль эрх зүй, бодлого, хөтөлбөрийн үндсэн тогтолцоонд хөндлөнгөөс оролцох зэрэг багтана.

### 3.3.2 Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх ажиллагааны хүрээ ба бүрэлдэхүүн хэсгүүд

Сүрьеэд өртсөн ард иргэдэд олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх хүрээ нь хэр чухал вэ? Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд үнэхээр оролцох шаардлагатай юу?

Олон нийтийг дайчлах үйл ажиллагааны талаарх бидний өмнөх ярилцлагаас дурдвал, бодлогын өөрчлөлтөд дуу хоолой, оролцоогоо нэгтгэх тухай бидний ярилцлагыг санаж байгаа байх. Энэ нь орон нутгийн тогтолцоог бэхжүүлэх тогтолцооны гол цөм нь юм. Учир нь энэ “хэмжээг нэмэгдүүлэх, чанартай, тогтвортой олон нийтэд түшиглэсэн хариу арга хэмжээ авах, тогтолцоог бэхжүүлэх”-ийг онцолж байгаа билээ. Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх тогтолцооны зургаан үндсэн бүрэлдэхүүн хэсэгт онцлон анхаарч байна.”<sup>55</sup> Энэ нь ч тогтолцоог бэхжүүлэх хүрээний зургаан үндсэн бүрэлдэхүүн хэсэгт тусгагдсан болно.<sup>56</sup>



## Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх хүрээний зургаан бүрэлдэхүүн хэсэг

1. Орчин болон нөлөөллийг идэвхжүүлэх. Үүнд бодлого, хууль эрх зүй, засаглалын орчныг сайжруулах, эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн олон нийтийн оролцоо, нөлөөллийн хүчин чармайлт орно.
2. Олон нийтийн сүлжээ, холбоо, түншлэл, зохицуулалт. Үр дүнтэй үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, сурталчлах, нөөц болоцоо ба нөлөөллийг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай, хамтын харилцааг бий болгох
3. Нөөц бололцоо ба чадавхийг бэхжүүлэх. Үүнд техникийн болон зохион байгуулалтын чадавхи бүхий хүний нөөц, санхүүжилт (үйл ажиллагааны болон үндсэн санхүүжилт), материаллаг нөөц бололцоо (дэд бүтэц, мэдээлэл, эрүүл мэндийн болон бусад бүтээгдэхүүн, технологи зэрэг зайлшгүй шаардлагатай бараа) орно.
4. Олон нийтийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх. Шаардлагатай бүх хүнд хүртээмжтэй, нотолгоонд тулгуурласан, нөөц бололцоо, хэрэгцээний талаарх олон нийтийн үнэлгээнд үндэслэсэн байна.
5. Байгууллага, манлайллыг бэхжүүлэх. Үүнд байгууллага, олон нийтийн тогтолцооны удирдлага, хариуцлага, манлайлал;
6. Хяналт, шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлт. Үүнд ХШҮ-ний систем, нөхцөл байдлын үнэлгээ, нотлох баримт бүрдүүлэх, судалгаа хийх, суралцах, төлөвлөлт, мэдлэгийн менежмент орно.

Эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрийг бэхжүүлэн үр дүнтэй ажиллаж чадвал дараахь зүйлст хувь нэмэртэй:

- Эрүүл мэнд, сайн сайхан байдлын үр дүн сайжирна;
- Хүмүүсийн эрүүл мэнд болон бусад эрхийг хүндэтгэнэ;
- Нийгмийн болон санхүүгийн эрсдэлээс хамгаална;
- Эрүүл мэнд, нийгмийн дэмжлэг, боловсрол болон бусад үйлчилгээний хүрээнд үзүүлэх арга хэмжээний хариу үйлдэл, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

### 3.3.3 Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд сүрьеэд өртсөн олон нийтийн оролцоо

Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх тодорхойлолт, зорилго, хамаарал болон түүний бүрэлдэхүүн хэсгийн талаарх бидний хэлэлцүүлэг нь сүрьеэд өртсөн олон нийтийг яагаад энэ үйл явцад татан оролцуулах нь чухал болох тухай ойлголтыг өгсөн. Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх нь бодлого боловсруулах болон засаглалын байгууллагуудад оролцоог институцичлэхэд чиглэгдсэн дайчлах үйл ажиллагааны олон нийтийн оролцоонд тулгуурладаг. Энэ нь сүрьеэтэй тэмцэх үндэсний стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой юм. Мөн сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдыг хянах, мэдээллийг сурталчлах, хөтөлбөр боловсруулахад ашиглах боломжийг олон нийтэд олгодог. Сүрьеэд өртсөн ард иргэдийн сүлжээний тогтвортой нэгдсэн хөдөлгөөн бий болгох, сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээ авахад олон нийтийг чадавхжуулах нь тогтолцоог бэхжүүлэхэд хэрхэн үр дүнтэй оролцохоос хамаарна.

Сүрьеэд өртсөн ард иргэдийг олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд татан оролцуулах талаар дараах хэдэн үйлдлийг авч үзэж болно:



**1. Олон нийтийн удирдагчид, сүрьеэд өртсөн олон нийт, хамааралтай байгууллагуудад чиглэсэн чадавхийг хөгжүүлэх олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.**

Үүнд дараах чиглэлээр мэдлэг, ур чадвар, хандлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байж болно<sup>57</sup>:

- Олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх үзэл баримтлал, түүний зургаан үндсэн бүрэлдэхүүн хэсгийн талаархи ойлголт
- Эрүүл мэндийн үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих, баримтжуулах, дүн шинжилгээ хийх нь хариуцлага, сурталчилгаа, бодлогын санаачлагыг хэрэгжүүлэх үндэс суурь болно:
  - Олон нийтийг хяналт, шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) үйл ажиллагаанд сургах, мөн хэрхэн үр дүнд хүргэх талаар
  - Сүрьеэгийн үйлчилгээний талаар олон нийтийн санал хүсэлтийг хэрхэн үнэн зөв цуглуулж, түүнийг бодлого, үйлчилгээний хөгжлийн янз бүрийн хүрээнд хэрхэн утга учиртай дамжуулах вэ
  - Төрөл бүрийн бүтэц дэх төлөөллийг хангах
  - Сүрьеэгийн төсвийн мөчлөгийн талаархи ойлголтыг хөгжүүлэх
  - Хэрэгжилтийн талаарх санал хүсэлтийг дэмжих, хариуцлага тогтоох, үйлчилгээг сайжруулах
- Үйлчилгээ, үйл ажиллагаа, бусад арга хэмжээг үр дүнтэй хүргэх, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хамгаалах, дэмжихэд үйлчилгээ үзүүлэгчид, үндэсний хөтөлбөрүүд, бодлого боловсруулагчид, орон нутгийн болон үндэсний удирдагчдын нийгмийн хариуцлагыг сурталчлах
- Нийгмийн дайчилгаа, олон нийтийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа, зохицуулалтыг бий болгох
- Олон нийтийн салбар дахь байгууллагын чадавхийг бэхжүүлэх, төлөвлөлт, манлайллыг хөгжүүлэх

**2. Сүрьеэгийн сүлжээ, байгууллагуудын үндэсний хийгээд орон нутгийн түвшний удирдагчид, гишүүдийг хариуцлагын тогтолцоонд түшиглэсэн хяналтыг/ олон нийт удирдсан хяналтад татан оролцуулах. Тодруулбал, энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотой.**

- ТББ болон ОНУБ-уудын эрүүл мэндийн бодлого, гүйцэтгэл, урьдчилан сэргийлэх, асаргаа, дэмжих үйлчилгээтэй холбоотой бүхий л үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээний чанарт байнгын хяналт тавих механизмыг бий болгож хэрэгжүүлэх. Үүнд:
  - Урьдчилан сэргийлэх, эмчилгээ, дэмжих үйлчилгээ
  - Хөтөлбөрийн санхүүжилт
  - Ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан тэгш бус байдал зэрэг хүрээлэн буй орчны асуудал, асуудлыг шийдвэрлэх

**3. Үйлчилгээ үзүүлэгчид, үндэсний хөтөлбөрүүд, бодлого боловсруулагчид, орон нутгийн болон үндэсний удирдагчдын нийгмийн хариуцлагын талаар сурталчлах ажлыг манлайлахын тулд Сүрьеэд өртсөн нутгийн иргэдийн удирдагчид, гишүүд, байгууллагуудыг дайчлах. Энэ нь хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах, дэмжихийн зэрэгцээ үйлчилгээ, үйл ажиллагаа болон бусад хөндлөнгийн оролцоог үр дүнтэй хүргэхэд чиглэгддэг.**

- Өвчний эсрэг хариу арга хэмжээ авахад чиглэсэн орон нутгийн болон үндэсний хэмжээнд зөвшилцөл, яриа хэлэлцээ, сурталчилгаа явуулах
- Сүрьеэ өвчнийг онцолж, тэргүүлэх олон зорилтын дунд ил байлгах
- Эмзэг бүлгийн хүн амын сүрьеэгийн тусламж, үйлчилгээг хүртэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах хууль тогтоомжийн шинэчлэл
- Үйлчилгээг сайжруулах талаар сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрт зөвлөмж өгөх үүднээс “харгалзагчийн” үүрэг гүйцэтгэнэ

**4. Сүрьеэд өртсөн олон нийтийг идэвхжүүлэх, олон нийтийн харилцаа холбоог бий болгох, хамтын ажиллагааг дэмжих, зохион байгуулалтыг хангахтай холбоотой үйл ажиллагаа явуулах:**

- Олон нийтийн байгууллагуудыг байгуулж, бусад оролцогчид болон өргөн хүрээний хөдөлгөөнүүдтэй холбоо тогтоох
- Олон нийт, Олон нийтийн оролцогчид болон бусад оролцогч талуудын хооронд албан бус болон албан ёсны бат бөх харилцааг бий болгох
- Бүс нутгийн сүрьеэгийн форум, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, нөлөөллийн кампанит ажил явуулах

**5. Сүрьеэд өртсөн орон нутгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, төлөвлөлт, манлайллыг хөгжүүлэх санаачлагыг хэрэгжүүлэх.**

- Төлөвлөлт, институци болон байгууллагын хөгжил, системийн хөгжил, хүний нөөц, манлайлал, Олон нийтийн салбарын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх



- Олон нийтийг тогтвортой, урьдчилан таамаглаж болохуйц санхүүгийн эх үүсвэрээр хангах, санхүүгийн эх үүсвэрийг олон нийтийн бүлгүүд, байгууллага, сүлжээгээр зохистой удирдах.
- Сүрьеэд өртсөн олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, нийгмийн идэвхижүүлэх, хяналт тавих, сурталчлаа ажилд шаардлагатай тохиолдолд техник, материаллаг болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- Сүрьеэгийн идэвхтэнийг сонгон шалгаруулах, сургах, удирдах, ажиллуулах үр дүнтэй тогтолцоо, ажилтны халаа сэлгээний төлөвлөлтийг агуулсан хүний нөөцийн тогтолцоог бий болгох.

Эцсийн эцэст, энэхүү тогтолцоог бэхжүүлэхэд олон нийтийн оролцоог эрэмбэлэх нь дараахь чиглэлээр удирдаж болно<sup>58</sup>:

**Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээтэй шууд хамтрах эсвэл бие даан эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх:**

- Эмнэлэг, лабораторийн үйлчилгээ зэрэг олон нийтийн түвшний байгууллагуудаар дамжуулан оношлогоо, эмчилгээ, тусламж үйлчилгээ
- ХДХВ-ийн халдварын талаарх явуулын зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээний хяналт, эрүүл мэндийн хөндлөнгийн оролцоо зэрэг Олон нийтийн эрүүл мэндийн арга хэмжээнүүд
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа Гэрийн эмчилгээ, сүрьеэгийн халдвар зэрэг Олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ
- Нийгмийн эрүүл мэндийн боловсрол, сурталчилгаа
- Хаягдсан, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх үйлчилгээ
- Эрүүл мэнд, халамжийн үйлчилгээний хүртээмжид нөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх, хянах

**Олон нийтийн түвшинд эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээг ашиглаж буй хувь хүмүүст зориулсан санаачлагыг дэмжих:**

- Орон нутгийн дэмжлэгтэй эрүүл мэндийн орчинд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ашиглалтыг дэмжихэд олон нийтийг дайчлах;
- Гэрийн нөхцөлд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх
- Эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнд хамрагдах лавлагаа, тусламж
- Үйлчилгээг ашиглах, дагаж мөрдөхөд хувь хүмүүст дэмжлэг үзүүлэх
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг бууруулах, зан үйлийг өөрчлөх арга хэмжээ
- Шинжилгээ, оношилгооны талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх
- Эмчилгээ, дагаж мөрдөх талаархи бичиг үсгийг сурталчлах
- Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтыг багасгах
- Хууль зүйн үйлчилгээг сурталчлах, хөнгөвчлөх
- Сэтгэл зүй, нийгэм, эдийн засгийн тусламж
- Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн даатгалын санаачлага
- Бэлэн мөнгө шилжүүлэх, халааснаасаа гарах зардал зэрэг үйлчилгээ авах санхүүгийн тусламж

**Дэмжих уур амьсгалыг бий болгох, сайжруулах арга хэмжээнд дараахь зүйлс орно:**

- Эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэх
- Бодлогын өөрчлөлт, сурталчилгаа, кампанит ажилд орон нутгийн болон үндэсний форумд оролцох
- Хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, хар тамхинд донтох, хүүхэд хамгаалал, нийгэм соёлын хор хөнөөлтэй зан үйл, түүнтэй

холбоотой асуудлаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх

- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах, дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлэх
- Бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл олж авах, хууль эрх зүйн арга хэмжээ авах, хувь хүн, гэр бүлийн нийгмийн дэмжлэг, халамжийн үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ.
- Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, үндсэн эрхийн мэдлэг, ядуурлыг бууруулах, үйлчилгээ, мэдээлэл, бараа бүтээгдэхүүн (жишээ нь, бэлгэвч, эм) хүртэхэд чиглэсэн хүүхэд, залуучуудад зориулсан боловсролын үйлчилгээ, дэмжлэг, олон нийтийг дайчлах
- Хөтөлбөр, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх

4-р хэсгийн 4.3-т дурдсан хэрэгслүүдийг олон нийтийн удирдагчид, гишүүд болон тэдний сүлжээнүүд олон нийтийн тогтолцоог бэхжүүлэх CSS-д оролцоход ашиглаж болно.

## 4-Р ХЭСЭГ

# Олон нийтийн оролцооны арга хэрэгслүүд

